

**ХУУЛИЙН ТӨСЛИЙН
ЗАРДЛЫН ТООЦООНЫ
ТАЙЛАН**

**ОЙН ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН
НАЙРУУЛГЫН ТӨСӨЛ**



Ерөнхий мэдээлэл

Ойн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг хэрэгжүүлэхэд гарах зардлын тооцооны судалгааг Европын Холбооны санхүүгийн дэмжлэгээр Ойн түншлэлийн хүрээнд “Ирээдүйн Ой” (F4F) техник туслалцаагаар боловсруулав. Энэхүү судалгааг Ойн газраас 2026 оны 04 дүгээр сарын 30, 5 дугаар сарын 07-ны өдөр ирүүлсэн Ойн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл дээр хийгдсэн болно. Судалгааны тайланд дурдагдсан тооцоолол дүгнэлт нь Европын Холбооны байр суурийг илэрхийлэхгүй, зөвхөн судлаачийн байр суурь болно. Судалгааны мэдээлэл бэлтгэхэд ашигласан аргазүй, аргачлалын зохистой, үнэн зөв байдлыг судлаач хариуцна.

Ойн түншлэл нь Европын Холбооны Global Gateway - Тогтвортой санхүүжилтийн стратегийн хүрээнд хэрэгжиж буй тэргүүлэх хөтөлбөр бөгөөд түнш орнуудын хооронд ойн нөөц, ойн экосистемийг хамгаалах, нөхөн сэргээх, тогтвортой ашиглахад чиглэсэн урт хугацааны хамтын ажиллагааны илэрхийлэл юм.

2026 ОН



FUNDED BY THE
EUROPEAN UNION



FORESTS FOR THE
FUTURE FACILITY



particip

АГУУЛГА

I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

1.1. Улсын төсвөөс санхүүжүүлж буй үйл ажиллагаа	5
1.2. Орон нутгийн төсвөөс санхүүжүүлж буй үйл ажиллагаа	6
1.3. Хуулийн этгээд ба иргэдийн санхүүжүүлж буй үйл ажиллагаа	7
1.4. Ойн салбарт орж буй санхүүжилтийн хүрэлцээ	8
1.5. Судалгааны зорилго	10

II. ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ЗАРДАЛ.....10

2.1. Төрийн захиргааны байгууллагын чиг үүргийг тодорхойлох	12
2.2. Хүний нөөцийг тодорхойлох	18
2.3. Гарах зардлыг урьдчилан тооцох	23
2.4. Үр дүнг тооцох	25
2.4.1. Мэдээллийн сан	26
2.4.2. Ойжуулалтын сан болон Нүүрстөрөгчийн сан	27
2.4.3. Ойн анги.....	30
2.4.3.1. Ойн ангийн одоогийн албан хаагчийн шатлал, зэрэглэл, цалин	31
2.4.3.2. Хуулийн төсөл, төслийн үзэл баримтлалын дагуу тооцсон ойн ангийн албан хаагчийн шатлал, зэрэглэл, цалин	31
2.4.5. Тусгай зориулалтын ой	34
2.5. Хувилбарыг нягталж, үр дүнг танилцуулах.	35
2.5.1. Тохиолдлын тоог багасгах боломж байгаа эсэх	35
2.5.2. Үйл ажиллагааны давтамжийг багасгах боломж байгаа эсэх	36

III. ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ЗАРДЛЫН ТООЦОО 36 |

IV. ИРГЭНД ҮҮСЭХ ЗАРДЛЫН ТООЦОО 38 |

V. ДҮГНЭЛТ 40 |

ЭХ СУРВАЛЖ 44 |

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. 2024 оны байдлаар хамгийн өндөр төсөвтэй сум дундын ойн анги, сая.төг	6
Хүснэгт 2. 2024 оны байдлаар хамгийн бага төсөвтэй сум дундын ойн анги, сая.төг	7
Хүснэгт 3. Ойгоор бүрхэгдсэн талбайн хэмжээ	8
Хүснэгт 4. Ойн салбартай холбоотой төсвийн орлого ба зарлагын суваг	9
Хүснэгт 5. Зардалд нөлөөлөх зүйл, хэсэг, заалт / чиг үүрэг/	10
Хүснэгт 6. Стандарт үйл ажиллагааг тодорхойлох нь	12
Хүснэгт 7. Стандарт үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд үүсэх хүний нөөцийн хэрэгцээ	19
Хүснэгт 8. Төрийн байгууллагын нэмэгдэж буй хүний нөөцийн ачаалал	22
Хүснэгт 9. Төрийн байгууллагын нэмэгдэж буй хүний нөөцийн ачаалал	23
Хүснэгт 10. Төрийн байгууллагын нэмэгдэж буй хүний нөөцийн цалингийн зардал	24
Хүснэгт 11. Нэг албан хаагчид оногдох материаллаг зардал /төг/	25
Хүснэгт 12. Материаллаг зардал /төг/	26
Хүснэгт 13. Цалингийн сангийн тооцоо, /төг/	28
Хүснэгт 14. Цалингийн сангийн тооцоо, /төг/	29
Хүснэгт 15. Албан хаасны болон зэрэг дэвийн нэмэгдлийн хувь хэмжээ	29
Хүснэгт 16. Хүний нөөцийн болон материаллаг зардал /төг/	30
Хүснэгт 17. Ойн ангийн албан хаагчийн ТҮ-9, ТҮ-8 шатлалын цалингийн дундаж тооцоо /төг/	30
Хүснэгт 18. Ойн ангид шаардагдах зардал /ТЗ, төг/	32
Хүснэгт 19. Боловсролын салбарын ТҮМ ангилалын зэрэглэлтэй адилтган тусдаа ангилал зэрэглэлээр тооцсон цалингийн зардал./төг/	32

Хүснэгт 20. Албан хаасны болон ур чадварын нэмэгдлийн хувь хэмжээ /хувь/	32
Хүснэгт 21. Ойн ангийн дарга ТЗ-5, мэргэжилтнийг ТҮМ-6 ангилал зэрэглэлээр тооцсон цалингийн зардал /төг/	33
Хүснэгт 22. Албан хаасны болон зэрэг дэв, ур чадварын нэмэгдлийн хувь хэмжээ	33
Хүснэгт 23. Хүний нөөцийн болон материаллаг зардал /төг/	33
Хүснэгт 24. Тусгай зориулалтын ойтой холбоотой хүний нөөцийн зардал /төг/	34
Хүснэгт 25. Төрийн байгууллагад үүсэх нийт зардлын хэмжээ /жилд, төг/	35
Хүснэгт 26. Хуулийн этгээдийн гаргаж өгөх мэдээллийн холбогдох зохицуулалт	37
Хүснэгт 27. Ойн ангийн албан хаагчийн шатлал, зэрэглэлийг өөрчлөн тооцсноос улсын төсөвт шинээр үүсэх зардлын зөрүү /төг/	42
Хүснэгт 28. Төрөөс гарах нийт зардал /төг/	42

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Улсын төсвийн ойжуулалт хөтөлбөрийн зардлын гүйцэтгэл, тэрбум.төг	5
Зураг 2. Шинжлэх ухаан технологийн сангийн бүтцийн жишээ	28

ОЙН ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСӨЛД ХИЙСЭН ЗАРДЛЫН ТООЦООНЫ ТАЙЛАН

I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ,

Ойн тухай хуулийг 2012 онд баталсан бөгөөд энэхүү хууль нь 12 бүлэг, 59 зүйлтэй. Тус хуулийн хүрээнд Монгол Улсын ойн нөөцийг хамгаалах, нөхөн сэргээх тогтвортой ашиглалтыг хангах, ойн экосистемийн тэнцвэр, биологийн олон янз байдлыг хадгалах, ойн нөөцийг эдийн засгийн үр өгөөжийг байгаль хамгаалалтай уялдуулах, орон нутгийн оролцоог хангахтай холбоотой зохицуулалтуудыг нэмж тусган, зарим зохицуулалтын хувьд нэмэлт, өөрчлөлт оруулахаар хуулийн төсөл боловсруулсан байна. Сүүлийн жилүүдэд Ойн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудал нэлээд яригдаж, 2022 онд 3 удаа, 2023 онд 2 удаа тус тус нэмэлт, өөрчлөлт оруулсан байна. Гэвч Ойн тухай хуультай холбоотой бодлогын асуудлыг тус нэмэлт, өөрчлөлтүүдийн хүрээнд бүрэн шийдвэрлэж чадаагүй байна.

Ойн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн хүрээнд одоогийн мөрдөгдөж буй хууль тогтоомжид буй харилцааг илүү нарийвчлан зохицуулж, нэр томъёог илүү оновчилж, хууль хэрэглээнд нэг мөр ойлгох ойлголтын хүрээг тодорхой болгосон ба ойн нөөцийг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх эрх зүйн үндсийг бэхжүүлэх, олон улсын жишигт нийцсэн тогтвортой ойн менежментийг бий болгох зорилготой байна.

Түүнчлэн салбарын санхүүжилтийн бүтэц, урсгал, хариуцлагын хуваарилалтад тодорхой өөрчлөлт хийгдэж байна. Гэхдээ эдгээр өөрчлөлтийн бодит нөлөөг үнэлэхийн тулд өнөөдөр ойн салбарын санхүүжилт яаж бүрдэж, хаашаа урсаж, түүгээр ямар байгууллагууд үйл ажиллагаа явуулж байгаа вэ гэдгийг эхлээд ойлгох шаардлагатай.


2023 оны байдлаар байгаль орчны салбарт нийт 147 төсөвт байгууллага үйл ажиллагаагаа эрхэлж байгаагаас улсын төсвөөс 83 байгууллага, орон нутгийн төсвөөс 64 байгууллага тус тус санхүүжсэн байна. Ойн салбарын хувьд улсын төсвөөс санхүүждэг ганц газар нь Ойн газар бол, орон нутгийн төсвөөс санхүүждэг 64 байгууллагын 48 нь сумын болон сум дундын ойн анги юм.

Дээрхээс харахаар одоогийн тогтолцоо нь олон байгууллага, олон төрлийн төсөвтэй, нарийн схем мэт боловч санхүүгийн урсгалын хувьд тийм ч төвөгтэй биш. Ойн газрын буюу улсын төсөв, орон нутгийн төсөв буюу сум дундын ойн ангийн төсвийн орлого, зарлагыг тодорхойлоход салбарын санхүүжилтийн ерөнхий дүр зураг харагдана. Өөрөөр хэлбэл, цөөн хэдэн суваг дээр салбарын санхүүжилт тогтож ирсэн байна.

1.1. Улсын төсвөөс санхүүжүүлж буй үйл ажиллагаа

Ойн газраас бусад байгаль орчны салбарын төрийн захиргааны байгууллагууд ихэнх нь бидний нэрлэдгээр “босоо” бүтэцтэй байгаа нь энэ харьцаанаас харагдана. Сав газрын захиргаа, цаг уур, орчны шинжилгээний чиглэлийн төрөлжсөн байгууллагууд, тусгай хамгаалалттай газруудын хамгаалалтын захиргаанууд энэхүү “босоо” бүтэцтэй хувилбарт хамаарч байна.

Зураг 1. Улсын төсвийн ойжуулалт хөтөлбөрийн зардлын гүйцэтгэл, тэрбум.төг



■ Батлагдсан ■ Зарцуулсан

Ойн тухай хууль 2012 онд батлагдсанаас хойш улсын төсөв дээр ойжуулах хөтөлбөрийн зардлыг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын багц дээр баталдаг болсон. Энэ зардал 2019 - 2022 оны хооронд Ковид цар тахлын нөлөөгөөр буурсан ч, 2022 оноос “Тэрбум мод” хөдөлгөөн идэвхжсэнээр төсөв нэмэгдэж, мөн 2022 оны нэмэлт өөрчлөлтөөр “Ойн газар” байгуулагдсанаар тус газрын төсөв дээр тавигдах болжээ. Харин 2025 онд 47.7 тэрбум төгрөг буюу түүхэн дэх хамгийн өндөр төсөв тавигдсан ч оны эхэн үеийн эдийн засгийн хүндрэлээс шалтгаалан улсын төсөвт тодотгол орсноор гүйцэтгэл 30.1 тэрбум болж буурсан байна.

Ойн газар нь 2024 оны байдлаар батлагдсан төсвийн 91%-ийг бусдаар гүйцэтгүүлэх ажил гэдэг зардлын ангиллаар ойжуулалт, нөхөн сэргээлт, хөнөөлт шавж, түймэртэй тэмцэх, ойн тооллого, зохион байгуулалт хийх зэрэг ажил үйлчилгээнд зарцуулсан байдаг. Ойн газар нь 39 ажилтны орон тоотой. 2024 оны байдлаар 1.6 тэрбум орчмын цалингийн зардал гаргаж ажилласан нь нийт зардлын 4 орчим хувь байжээ.

1.2. Орон нутгийн төсвөөс санхүүжүүлж буй үйл ажиллагаа

Орон нутгийн төсвөөс аймаг, сум, сумдын дундын нийт 48 ойн анги санхүүждэг. 2023 оны байдлаар эдгээр ойн ангиудын зардал нь салбарын орон нутгийн нийт төсвийн зардлын 6.2 хувь буюу 5.9 тэрбум төгрөгийг эзэлж байсан бөгөөд нэг ойн ангид жилд дунджаар 149 орчим сая төгрөг зарцуулж байсан гэж тооцжээ.¹

Ойн ангиудаас Өмнөговь аймгийн Ойн ангийн төсвийн зардал хамгийн их буюу 2024 оны байдлаар 3,159.3 сая төгрөг, үүнээс аймгийн төсвөөс хийж буй санхүүжилт 1,644.3 сая байна. Тус байгууллагын нийт зардлыг ойжуулах хөтөлбөрт зарцуулж байгаа аж. Нэг бол уул уурхайн орлого өндөртэй, нэг бол ойн нөөц ихтэй, түүнийг сайн ашигладаг газрын сум дундын ойн ангиуд санхүүжилт өндөртэй байгааг бид анзаарч болно.

Хүснэгт 1. 2024 оны байдлаар хамгийн өндөр төсөвтэй сум дундын ойн анги, сая.төг

Нийт төсвөөр		Нийт төсөв дэх орон нутгийн төсвийн санхүүжилт	
Даланзадгад Сум дундын ойн анги (Өмнөговь)	3,159.29	Даланзадгад Сум дундын ойн анги (Өмнөговь)	1,644.36
Цогт-Овоо Сум дундын ойн анги (Өмнөговь)	1,593.96	Баян-Өндөр Сум дундын ойн анги (Орхон)	425.33
Баян-Өндөр Сум дундын ойн анги (Орхон)	880.31	Говь-Сүмбэр Сум дундын ойн анги (Говьсүмбэр)	274.55
Өвөрхангай Сум дундын ойн анги (Өвөрхангай)	592.21	Сэврэй Сум дундын ойн анги (Өмнөговь)	236.75

¹ fao/eu/undp, 2024. байгаль орчны салбарын төсвийн зарлагын шинжилгээ

Их тамир Сум дундын ойн анги (Архангай)	423.02	Баянхонгор Сум дундын ойн анги (Баянхонгор)	225.93
-----------------------------------------------	--------	---------------------------------------------------	--------

Харин хамгийн бага төсөвтэй сум дундын ойн анги нь Дорнод аймгийн Булган сумын ойн анги байна. Тус сум дундын ойн анги нь зөвхөн орон нутгийн төсвөөс санхүүждэг, үйл ажиллагааны орлого олдоггүй. Харин Сэлэнгэ аймгийн Ерөө бүсийн сум дундын ойн анги нь орон нутгийн төсвөөс хамгийн бага дэмжлэг авдаг мөртлөө нийт төсөв нь 330 орчим сая байгаа нь мод бэлтгэл их явагддаг газар сум дундын ойн ангийн өөрийн үйл ажиллагааны орлого бараг 300 сая төгрөг байгаагаас хамаарчээ.

Хүснэгт 2. 2024 оны байдлаар хамгийн бага төсөвтэй сум дундын ойн анги, сая.төг

Нийт төсвөөр /сая, төг/		Нийт төсөв дэх орон нутгийн төсвийн санхүүжилт /сая.төг/	
Мөнгөнморьт сум дундын ойн анги (Төв)	123.31	Сэлэнгэ бүс сум дундын ойн анги (Сэлэнгэ)	87.17
Хялганат сум дундын ойн анги (Булган)	122.54	Орхон бүс сум дундын ойн анги (Сэлэнгэ)	68.70
Орхон бүс сум дундын ойн анги (Сэлэнгэ)	104.04	Халх гол сум дундын ойн анги (Дорнод)	58.78
Халх гол сум дундын ойн анги (Дорнод)	58.87	Булган сум дундын ойн анги (Дорнод)	49.64
Булган сум дундын ойн анги (Дорнод)	49.64	Ерөө бүс сум дундын ойн анги (Сэлэнгэ)	35.51

Ойжуулах арга хэмжээнд зарцуулах зардал байгаль орчны хамгаалах зориулалтын арга хэмжээнд улсын төсвөөс зарцуулсан зардлын бага хэсгийг эзэлдэг. Жишээ нь, 2023 оны байдлаар байгаль орчныг хамгаалах зориулалтын арга хэмжээнүүдэд зарцуулсан зардлын 55.6 хувь буюу 46.2 тэрбум төгрөгийг агаарын бохирдлыг бууруулах арга хэмжээнд, 26.1 хувь буюу 21.7 тэрбум төгрөгийг байгаль орчин хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд, 15.9 хувь буюу 13.3 тэрбум төгрөгийг ойжуулах арга хэмжээнд, 2.0 хувь буюу 1.6 тэрбум төгрөгийг ус цаг уурын судалгаа, шинжилгээний арга хэмжээнд, 0.4 хувь буюу 0.3 тэрбум төгрөгийг ургамал хамгааллын арга хэмжээнд тус тус зарцуулсан байна.

1.3. Хуулийн этгээд ба иргэдийн санхүүжүүлж буй үйл ажиллагаа

Ойн тухай хуулиар иргэд болон аж ахуйн нэгжүүдэд шууд төлбөр, татвар ногдуулдаг зохицуулалт үндсэндээ байхгүй. Ойгоос мод бэлтгэж ашигладаг аж ахуйн нэгжүүд буюу Ойн мэргэжлийн байгууллагууд (ОМБ) нь зөвхөн Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуульд заасан хувь хэмжээгээр төлдөг бөгөөд энэ харилцаа нь Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулиар зохицуулагддаг. Өөрөөр хэлбэл, ойн салбарын хувийн хэвшилд ногдох санхүүгийн үүрэг тодорхой, харин иргэдэд шууд зардал ногдуулдаг зохицуулалт байхгүй.

Гэвч Ойн тухай хуулиар “сайн дурын” үндсэн дээр байгуулагдах боломжтой гэж заасан ойн нөхөрлөл нь эрх зүйн хувьд иргэдийн оролцоонд тулгуурласан бүтэц атлаа ой хамгаалах, хөнөөлт шавжтай тэмцэх, хяналт хийх зэрэг тодорхой мэргэжлийн үүрэг хүлээдэг. Гэтэл ийм үүрэг хүлээсэн ч энэ үүргийг санхүүжүүлэх эх үүсвэрийг тодорхой заагаагүй юм.

Үүний үр дүнд нь ойн нөхөрлөлийн гишүүд ой хамгааллын үйл ажиллагааны зардлыг өөрсдөө хувиасаа гаргах шаардлагатай болжээ. Өөрөөр хэлбэл ойн нөхөрлөл гэдэг институтыг хуульчилсан нь иргэдийн хувьд шууд зардлын ачаалал үүсэх үндэслэл болж хувирсан байна. Ойн нөхөрлөл үйл ажиллагаа тасралтгүй явуулахын тулд иргэдээс наад зах нь эргүүл хийхэд ашиглах шатахуун гэх мэт шууд зардал гарахаас гадна өөр зүйлд зарцуулах цаг хугацааны алдагдсан боломж гарч байдаг. Эндээс үзэхэд хуулийн “сайн дурын” шинж нь бодит амьдрал дээр “өөрийн хөрөнгөөр санхүүжүүлэх үүрэгтэй” гэсэн үг болжээ.

Орлого олох боломжгүй, санхүүгийн дэмжлэг тодорхойгүй учраас Ойн нөхөрлөлүүд орлого олох олон хувилбар туршсан байдаг. Үүнд:

- Хушны самрын эрх эзэмшигчидтэй хамтрах
- Ой цэвэрлэгээний ажлыг өөрсдөө хийж, унанги мод бэлтгэх
- Мод үржүүлэг, ойжуулалтын үйлчилгээ үзүүлэх
- Зарим тохиолдолд жижиг хэмжээний мод бэлтгэх оролдлого хийсэн

Гэвч эдгээр оролдлогууд нь ой мэргэжлийн байгууллагуудын үйл ажиллагаатай давхцах, зах зээл дээр өрсөлдөх чадваргүй байх, эрх зүйн тодорхойгүй байдал, санхүүгийн тогтвортой бус байдал зэрэг шалтгаанаар амжилттай тогтворжиж чадсангүй. Институцийн хувьд “үүрэгтэй боловч орлогогүй” бүтэц учраас олон ойн нөхөрлөлүүд үйл ажиллагаагаа зогсоохоос өөр аргагүйд хүрсэн.

1.4. Ойн салбарт орж буй санхүүжилтийн хүрэлцээ

2023 оноос Ойн газраар дамжин санхүүжүүлсэн төсөв огцом нэмэгдсэн ч үүний хүрээнд Ойн тухай хуулийн бүх заалтыг хэрэгжүүлэхэд шаардлагатай санхүүжилт төвлөрч эхэлсэн гэж үзвэл мөн өрөөсгөл юм. Ойн газраас 2024 онд боловсруулсан Улсын ойн менежментийн төлөвлөгөөнд “ерөнхий менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд нэг жилд 31,035.86-774,516.34 сая төгрөгийн санхүүжилт шаардагдаж байгаа бөгөөд 10 жилийн хугацаанд тус ойн менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд нийт 4,042,534.19 сая төгрөгийн санхүүжилт шаардагдаж байна. Үүнийг бүгдийг улсын төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэхээр төлөвлөсөн болно” гэжээ. Өөрөөр хэлбэл улсын хэмжээнд ойн менежментийн хамгийн наад захын үйл ажиллагааг 10 жилийн турш бүрэн явуулахад 4 их наяд төгрөг шаардлагатай, санхүүжилтийн оновчтой хувилбар бий болгож чадахгүй бол энэ ачаалал 100% улсын төсөв дээр буух ажээ.

Энэ тоо анхны харагдах байдлаараа өндөр мэт санагдаж болох ч Монгол Улсын ойн экологи-эдийн засгийн үнэлгээтэй харьцуулан үзвэл өөрөөр харагдана. Монгол Улс ой багатай улс гэсэн нийтлэг ойлголт түгээмэл боловч олон улсын харьцуулалтаар авч үзвэл энэ нь үнэн биш. Ойгоор бүрхэгдсэн талбайн хэмжээгээр Монгол Улс Норвеги улстай дүйцэхүйц бөгөөд Австри, БНСУ зэрэг өндөр хөгжилтэй орнуудаас илүү их ойтой орны тоонд ордог.

Хүснэгт3. Ойгоор бүрхэгдсэн талбайн хэмжээ (сая.га)

Норвеги	Австри	Өмнөд Солонгос	Финлянд	Япон	Монгол
12.0	4.3	6.3	20.3	25.0	13.6

Сүүлийн тооцооллоор монголын ойн экологи-эдийн засгийн нийт үнэлгээ 909 их наяд төгрөгт хүрсэн нь ой экосистемийн үнэ цэнэ, байгалийн нөөцийн үйлчилгээ, нүүрстөрөгчийн шингээлт, усны зохицуулалт, хөрсний хамгаалал зэрэг олон талт өгөөжийг багтаасан цогц үнэлгээ юм. Өөрөөр хэлбэл 909 их наяд төгрөгийн хөрөнгийн ашиглалт үйлчилгээнд арван жилийн турш зарцуулах зардал 4 их наяд байна гэдэг тийм ч боломжгүй зүйл биш юм.

Ойн салбарын санхүүжилт нь улсын, аймаг, сумын төсөв болон ойгоос бий болдог ашиглалтын төлбөрүүдийн хоорондын харилцан хамаарал бүхий хэдхэн сувагт тулгуурлан бүрддэг.

Эдгээр сувгууд нь орлого ба зарлагын урсгалыг тодорхойлж, салбарын байгууллагуудын үйл ажиллагааны санхүүгийн үндсийг бүрдүүлдэг институцийн тогтолцоог бий болгож байна.

Улсын төсвийн хувьд хушны самрын дуудлага худалдаанаас төвлөрөх орлогын 50 хувийг Байгаль орчны уур амьсгалын сангаар дамжуулан улсын төсөвт төвлөрүүлдэг бөгөөд энэ эх үүсвэр нь Ойн газрын үйл ажиллагааг санхүүжүүлэх үндсэн суурь болдог. Аймгийн төсвийн түвшинд шууд орлого төвлөрдөггүй ч Сум дундын ойн ангиудын (СДОА) үйл ажиллагааг санхүүжүүлэх зардлыг бүрэн хариуцдаг. Харин сумын төсөвт хушны самрын дуудлага худалдааны үлдсэн 50 хувь болон ойн нөөц ашигласны төлбөр (БНАТ) төвлөрч, эдгээр орлогоос БНАТ-ийн 85-аас доошгүй хувийг эргүүлэн ойн аж ахуйн үйл ажиллагаанд зарцуулах, мөн сумын ойн ангийн үйл ажиллагааг санхүүжүүлэх үүрэгтэй.

Хүснэгт4. Ойн салбартай холбоотой төсвийн орлого ба зарлагын суваг

	Орлого	Зарлага
Улсын төсөв	Хушны самрын дуудлага худалдааны орлогын 50%-ийг Байгаль орчин уур амьсгалын сангаар дамжуулан улсын төсөвт төвлөрүүлдэг	Ойн газрын үйл ажиллагааг улсын төсвөөс санхүүжүүлж байна.
Аймгийн төсөв	-	Сум дундын ойн ангиудын үйл ажиллагааг аймгийн төсвөөс санхүүжүүлж байна
Сумын төсөв	Дараах орлогууд төвлөрдөг <ul style="list-style-type: none"> Хушны самрын дуудлага худалдааны орлогын 50% Ойн нөөцийн байгаль орчны нөөц ашигласны төлбөр 	Дараах зардлыг санхүүжүүлдэг <ul style="list-style-type: none"> Байгалийн нөөц ашигласны 85%-с багагүй хувийг эргүүлэн Сумын ойн ангийн үйл ажиллагаа

Дараагийн бүлгүүдэд Хууль тогтоомжийн тухай хуулийн² 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэгт “Хууль тогтоомжийн төслийг баталснаар тухайн хууль тогтоомжийн үйлчлэх хүрээнд хамрагдах иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагын үйл ажиллагаанд үүсэх зардлын тооцоог тухай бүр гаргаж, зардал, үр өгөөжийн харьцааг энэ хуулийн 12.1.4-т заасан аргачлалын дагуу тодорхойлно.” гэж заасны дагуу Ойн тухай хуулийн шинэчилсэн найруулгын хуулийн төсөл батлагдсанаар уг хуулийн үйлчлэх хүрээнд хамаарах иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагын үйл ажиллагаанд үүсэх зардлыг Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо хийх аргачлал” /цаашид “аргачлал” гэх/-ын дагуу тооцов. Энэхүү аргачлалын дагуу судалгааг хийж тайланг боловсруулахдаа одоо байгаа төсвийг тодорхойлж, харьцуулалтыг тусгасан болно.

1.5. Судалгааны зорилго

Ойн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл батлагдсанаар уг хуулийг хэрэгжүүлэх иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагад үүсэх зардал, ачааллыг тооцож, зардлыг бууруулах боломжит хувилбар бүхий санал боловсруулах, зардал, үр өгөөжийн харьцааг үнэлэхэд энэхүү судалгааны зорилго чиглэгдэнэ.

Төрийн байгууллагын зардлыг тухайн ажил үйлчилгээг гүйцэтгэхэд шаардагдах хүний нөөцийн хэрэгцээнд, хуулийн этгээдийн зардлыг хууль тогтоомжоор төрийн байгууллагаас бусад аж ахуйн нэгж, байгууллагад хүлээлгэж байгаа үүргийг хэрэгжүүлэхэд зарцуулах мөнгөн зардалд, иргэнд үүсэх зардлыг хууль тогтоомжоор иргэнд хүлээлгэж байгаа үүргийг хэрэгжүүлэхтэй

² “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2015 оны 7 дугаар сарын 03-ны өдрийн 25 дугаарт нийтлэгдсэн.

холбогдуулан зарцуулах цаг хугацаанд тус тус үндэслэн тооцохоор Аргачлалд заасан. Иймд хуулийн төсөл батлагдсанаар үүсэх зардлын тооцоог хийхдээ дараах нийтлэг зарчмыг баримтлав. Үүнд:

- Хуулийн этгээд, төрийн байгууллагын гүйцэтгэх үүрэг нэг бүрийг оновчтой тодорхойлох;
- Үүрэг гүйцэтгэхэд зарцуулах хугацааг тогтооход бодитой хандах;
- Бодит тоо баримт, мэдээлэлд тулгуурлах;
- Аргачлалд заасан тооцоо хийх үе шатыг баримтлах.

Судалгааны үр дүнд үндэслэн, тус хуулийн төсөл батлагдсанаар үүсэх зардлыг тооцон, зардал ба үр өгөөжийн харьцааг дүгнэв.

II. ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ЗАРДЛЫН ТООЦОО

Төрийн байгууллагын зардал буюу улсын төсөвт үүсэх ачааллыг тооцохын тулд тухайн хуулийн төсөлд шинээр тусгасан чиг үүргийг гүйцэтгэхэд шаардагдах хүний нөөцийн хэрэгцээг тодорхойлж, түүнд шаардагдах зардлыг тооцох бөгөөд уг ажлыг дараах үе шаттайгаар зохион байгуулна:

- Байгууллагын гүйцэтгэх чиг үүргийг тодорхойлох;
- Тухайн чиг үүргийг гүйцэтгэхэд шаардагдах хүний нөөцийг тодорхойлох;
- Холбогдон гарах зардлыг урьдчилан тооцох/цалингийн зардал, материаллаг зардал, нэг удаагийн зардал/;
- Зардлыг нэгтгэн тооцох;
- Хувилбарыг нягталж, үр дүнг нэгтгэх.

Хүснэгт 5.Зардалд нөлөөлөх зүйл, хэсэг, заалт / чиг үүрэг/

Хуулийн төслийн төрийн байгууллагын гүйцэтгэх чиг үүрэгтэй холбогдох зохицуулалт	Чиг үүргийг хэрэгжүүлэхэд нөлөөлөх зүйл заалт
12.1.Тусгай зориулалтын ойг ойн нөөцийг хамгаалах, хот, суурины ногоон бүсийг хөгжүүлэх, түүх, соёлын үнэт зүйлсийг хамгаалах, нийгмийн эрэлт хэрэгцээг хангах зорилгоор тусгай зориулалтын ойг тогтооно.	-
15.1.Улсын ойн менежментийн төлөвлөгөөг Засгийн газар батална.	-
15.6.Улсын ойн менежментийн төлөвлөгөөнд туссан ойжуулалтын төслийн техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулах ажлыг ойн асуудал хариуцсан төрийн байгууллага хариуцан зохион байгуулна.	-
15.7.Техник, эдийн засгийн үндэслэлийг ойн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хянаж баталгаажуулна.	-
18.1.Хушин ой нь экологийн хувьд эмзэг, эдийн засгийн ач холбогдолтой тул тусгайлсан менежментийн дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ:	-
19.7.Энэ хуулийн 19.1.2-т заасны дагуу ойжуулалтын зориулалтаар эзэмшүүлэх газрыг олгох асуудлыг төсөл сонгон шалгаруулах замаар шийдвэрлэнэ.	-
19.9.Улс, аймаг, нийслэлийн ойн менежментийн төлөвлөгөөнд ойжуулалт хийхээр төлөвлөсөн газарт хийх ойжуулалт хийх хуулийн этгээдийг төсөл сонгон шалгаруулалтаар сонгоно. 19.11.1.ойн шалгуур үзүүлэлтийг хангасан гэж үзвэл ойн мэдээллийн цахим системд тухайн таримал ойг бүртгэж, цахим гэрчилгээ олгоно.	-

<p>23.8.Ойгоос бэлтгэсэн мод, модон материалыг аймаг, сум, хот, суурины хооронд тээвэрлэх, худалдахдаа цахим гарал үүслийн гэрчилгээтэй байна. Гэрчилгээг тухайн орон нутгийг хариуцсан ойн анги цахим системээр олгоно.</p>	-
<p>24.1.Ойн модны нөөцийг Монгол Улсын хуулийн этгээдэд төсөл сонгон шалгаруулах замаар сумын ойн менежментийн төлөвлөгөөний дагуу 10 жилийн хугацаатай гэрээгээр ашиглуулж болно.</p> <p>24.2.Төсөл сонгон шалгаруулалтыг цахим хэлбэрээр зохион байгуулна.</p>	-
<p>30.3.Ойн үр, үржлийн материалын гарал үүслийн гэрчилгээг ойн анги цахимаар олгоно.</p>	-
<p>47.1.Ойн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага ойн, ойн баялгийн нөөц, түүний ашиглалт, хамгаалалт, нөхөн сэргээлт, менежменттэй холбоотой мэдээллийг бүрдүүлэх, бүртгэх, хадгалах, боловсруулах, солилцох, ашиглах зорилгоор улсын хэмжээний ойн мэдээллийн цахим систем ажиллуулна.</p>	-
<p>47.3.Ойн мэдээллийн цахим системд дараах мэдээллээс бүрдэнэ:</p> <p>47.3.1.ойн бүсийн ангилал, хил зааг, байршил, талбай; 47.3.2.ойн тооллого, ой зохион байгуулалтын мэдээлэл; 47.3.3.ойн менежментийн төлөвлөгөө (улсын, аймаг, нийслэл, сум); 47.3.4.зөвшөөрөл, гэрээ, ашиглалтын эрхийн мэдээлэл; 47.3.5.мод бэлтгэл, ойн дагалт баялаг, самрын ашиглалтын бүртгэл; 47.3.6.ойжуулалт, нөхөн сэргээлт, арчилгаа, хамгаалалтын арга хэмжээ; 47.3.7.ойн нүүрстөрөгч шингээлт, ялгаралтын бүртгэл, зах зээл, төслийн мэдээлэл; 47.3.8.түймэр, хөнөөлт организм, байгалийн гамшгийн мэдээлэл; 47.3.9.хяналт шалгалт, зөрчил, авсан арга хэмжээний мэдээлэл; 47.3.10.ойн туршилт, судалгааны байнгын болон түр талбайн байршил, арчилгааны мэдээлэл; 47.3.11.нөхөрлөлийн үйл ажиллагаа, гэрээ, тайлан, талбайн мэдээлэл; 47.3.12.сонгон шалгаруулалтын мэдээлэл, гэрээ, талбайн хил зааг, хүлээх үүрэг, хөрөнгө оруулалт, тайлангийн мэдээлэл; 47.3.13.хөрөнгө оруулалтын төсөл, санхүүжилтийн мэдээллийг 47.3.14.хуульд заасан бусад мэдээлэл.</p>	-
<p>48.5.Зөвшөөрөл, гэрээ, тайлан, ашиглалтын үйл ажиллагааг ойн мэдээллийн цахим системд бүртгэснээр хүчин төгөлдөрт тооцно.</p>	-
<p>49.1.Ойн баялгийг хамгаалах, нөхөн сэргээх, ойжуулах, мониторинг хийх, ойн тооллого, ой зохион байгуулалт, ойн мэдээллийн цахим системийн хэвийн үйл ажиллагааг хангах, орон нутгийн оролцоог дэмжих, салбарын тогтвортой санхүүжилтийг бүрдүүлэх зорилгоор ойжуулалтын сантай байна.</p>	-
<p>51.1.Ойн нүүрстөрөгчийн шингээлт, ялгаралтай холбоотой төсөл, бүртгэл, баталгаажуулалт, орлогын хуваарилалт, зах зээлийн оролцоог дэмжих зорилгоор Нүүрстөрөгчийн сантай байж болно.</p>	-
<p>51.4.Ойн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нүүрстөрөгчийн сангийн талаар дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:</p> <p>51.4.1.нүүрстөрөгчийн төсөл, бүртгэл, баталгаажуулалтын техникийн санал боловсруулах;</p>	-

<p>51.4.2.төсөл, арга хэмжээний хэрэгжилт, мониторинг, мэдээллийг нэгтгэх;</p> <p>51.4.3.орлогын хуваарилалтын шалгуур, тооцоог боловсруулах.</p>	
<p>53.5.Ойн тогтвортой менежментийн баталгаажуулалтыг сайн дурын үндсэн дээр гуравдагч этгээдээр хөндлөнгийн байдлаар үнэлүүлж баталгаажуулна.</p>	
<p>53.6.Ойн тогтвортой менежментийн баталгаажуулалтыг Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуульд заасны дагуу итгэмжлэгдсэн, эсхүл бүртгүүлсэн баталгаажуулалтын байгууллага /цаашид "баталгаажуулалтын байгууллага" гэх/ гүйцэтгэнэ.</p>	-

2.1. Төрийн захиргааны байгууллагын чиг үүргийг тодорхойлох

Байгууллагын чиг үүргийг тодорхойлоход дараах зарчмыг баримтална. Үүнд:

- Тухайн хууль тогтоомжид хамаарах төрийн байгууллага, тэдгээрийн чиг үүргийг тодорхойлох;
- Байгууллагыг сонгохдоо тухайн чиг үүрэгт хамааралтай, голлон үүрэг гүйцэтгэх байгууллагыг сонгох;
- Чиг үүрэгт хэрэгжүүлэх, хэмжих боломжтой агуулгыг хамааруулах.

Чиг үүргийг тодорхойлохдоо гүйцэтгэх үйлдэл буюу стандарт үйл ажиллагааг тодорхойлно. Иймд Засгийн газраас баталсан 59 дүгээр тогтоол дах аргачлалын хүрээнд төрийн байгууллагаас бодлогын шинжтэй зарим ажил, үйлчилгээг зардлын тооцоонд хамааруулан тооцдоггүй бөгөөд стандарт үйл ажиллагааг тодорхойлохдоо ерөнхий байдлаар бүлэглэн тодорхойлов.

Хүснэгт 6.Стандарт үйл ажиллагааг тодорхойлох нь

Гүйцэтгэх байгууллага	Гүйцэтгэх ажил үүрэг	Стандарт үйл ажиллагаа
<p>Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага</p>	<p>таримал ойг ойн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаас тогтоосон журмын дагуу бүртгэсэн байх.</p> <p>Ашиглалтын бүсийн ойн доройтол, нөөцийн хомсдол, экологийн эрсдэл нэмэгдсэн нь үнэлгээ, хяналт-шинжилгээгээр тогтоогдсон тохиолдолд тухайн бүсэд ашиглалтын хэмжээг бууруулах, түр зогсоох, ангиллыг өөрчлөх, нөхөн сэргээлтийн тусгай дэглэм тогтоох шийдвэрийг ойн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага гаргана.</p>	<ul style="list-style-type: none"> • Таримал ойн байршил, хэмжээ, төрөл зүйлийн мэдээллийг бүрэн цуглуулах • Ойн нөөцийн анхан шатны үнэлгээ хийх • Холбогдох баримт бичгийг бүрдүүлэх (газрын зөвшөөрөл, тарилтын тайлан гэх мэт) • Ойн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүсэлт гаргах • Тухайн байгууллагаас тогтоосон журмын дагуу хяналт, шалгалт хийлгэх • Таримал ойг албан ёсны бүртгэлд бүртгүүлэх • Бүртгэлийн мэдээллийг мэдээллийн санд оруулах, шинэчлэх • Тогтмол тайлагнал, хяналтанд хамрагдах • Ойн доройтол, нөөцийн өөрчлөлтийн талаарх мэдээллийг цуглуулах • Үнэлгээ, хяналт-шинжилгээ (мониторинг) тогтмол хийх

		<ul style="list-style-type: none"> ● Экологийн эрсдэлийг тодорхойлох, дүгнэлт гаргах ● Эрсдэл, доройтол илэрсэн эсэхийг албан ёсоор баталгаажуулах ● Шаардлагатай тохиолдолд дараах арга хэмжээнүүдийг судалж төлөвлөх: ● Ашиглалтын хэмжээг бууруулах ● Ашиглалтыг түр зогсоох ● Ойн ангиллыг өөрчлөх ● Нөхөн сэргээлтийн тусгай дэглэм тогтоох ● Шийдвэрийн төсөл боловсруулах ● Холбогдох байгууллагуудтай зөвшилцөх ● Ойн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас албан ёсны шийдвэр гаргах ● Шийдвэрийг хэрэгжүүлэх, олон нийтэд мэдээлэх ● Хэрэгжилтэд хяналт тавих, үр дүнг үнэлэх
	<p>Ашиглалтын хэмжээ, хэлбэр, хугацааг тогтоохдоо ойн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас баталсан дараах шалгуурыг харгалзан үзнэ:</p> <ul style="list-style-type: none"> - ойн нөөцийн үнэлгээ; - нөхөн сэргэх чадавх; - экосистемийн даац; - насны бүтэц, төрөл зүйлийн бүрэлдэхүүн; - хөрс, ус, амьдрах орчинд үзүүлэх нөлөөлөл; - түймэр, хөнөөлт шавж, өвчин зэрэг хөнөөлт хүчин зүйлийн эрсдэл; - орон нутгийн амьжиргаа, уламжлалт хэрэглээний хэрэгцээ. <p>Аймаг, нийслэлийн ойн менежментийн төлөвлөгөөг ойн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална. Сумын ойн менежментийн төлөвлөгөөг аймгийн Засаг дарга баталж, төрийн захиргааны төв байгууллага бүртгэнэ.</p>	<ul style="list-style-type: none"> ● Ойн нөөцийн талаарх суурь мэдээлэл цуглуулах ● Ойн нөөцийн үнэлгээ хийх ● Ойн нөхөн сэргэх чадавхыг тодорхойлох ● Экосистемийн даацын үнэлгээ хийх ● Ойн насны бүтэц, төрөл зүйлийн бүрэлдэхүүнийг судлах ● Ашиглалтын хөрс, ус, амьдрах орчинд үзүүлэх нөлөөллийг үнэлэх ● Түймэр, хөнөөлт шавж, өвчин зэрэг эрсдэлийг тодорхойлох ● Орон нутгийн амьжиргаа, уламжлалт хэрэглээний хэрэгцээг судлах ● Дээрх шалгуур үзүүлэлтүүдийг нэгтгэн дүгнэлт гаргах ● Ашиглалтын хэмжээ, хэлбэр, хугацааны санал боловсруулах ● Холбогдох байгууллагуудтай зөвшилцөх ● Ойн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаар батлуулах ● Батлагдсан шийдвэрийг хэрэгжүүлэх, хяналт тавих ● Аймаг, нийслэл, сумын түвшинд ойн менежментийн төлөвлөгөө боловсруулах ● Төлөвлөгөөг мэргэжлийн байгууллагаар хянуулж, сайжруулах ● Аймаг, нийслэлийн төлөвлөгөөг төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх

		<ul style="list-style-type: none"> ● Төв байгууллага төлөвлөгөөг хянаж, батлах ● Сумын ойн менежментийн төлөвлөгөөг аймгийн Засаг даргад хүргүүлэх ● Аймгийн Засаг дарга төлөвлөгөөг хянаж, батлах ● Батлагдсан сумын төлөвлөгөөг төрийн захиргааны төв байгууллагад бүртгүүлэх ● Бүртгэлийн мэдээллийг улсын нэгдсэн санд оруулах ● Төлөвлөгөөний хэрэгжилтийг зохион байгуулах ● Хэрэгжилтэд тогтмол хяналт-шинжилгээ хийх ● Үр дүнг тайлагнах, шаардлагатай бол төлөвлөгөөг шинэчлэх
	<p>- Тусгай зориулалтын ойд дараах үйл ажиллагааг ойн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын зөвшөөрөл, батлагдсан менежментийн төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлж болно:</p> <p>- Тусгай зориулалтын ойд хэрэгжүүлэх менежментийн төлөвлөгөөг боловсруулж, ойн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаар батлууна.</p> <p>- Эзэмшлийн ойд энэ хууль болон улсын, аймаг, сумын ойн менежментийн төлөвлөгөөнд нийцсэн менежментийн төлөвлөгөө боловсруулж, ойн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаар батлууна.</p> <p>- Эзэмшлийн ойн менежментийн төлөвлөгөөг ноцтой зөрчсөн тохиолдолд ойн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага дараах арга хэмжээг авч болно:</p> <ul style="list-style-type: none"> - төлөвлөгөөг өөрчлөхийг шаардах; - хэрэгжилтийг түр түдгэлзүүлэх; - гэрээний хэрэгжилтийг дүгнэх; - гэрээг цуцлах. <p>Ойн мэдээллийн нэгдсэн системийг ойн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хариуцан хөгжүүлж, хөтөлж, улсын хэмжээнд нэгдсэн стандартын дагуу ажиллуулна.</p> <p>Ховор, эмзэг, нөхөн төлжилт удаан дагалт баялгийн ашиглалтад тусгай хамгаалалт, хязгаарлалтыг ойн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага тогтооно.</p> <p>Ойн дагалт баялгийн ашиглалтын мэдээллийг ойн мэдээллийн нэгдсэн системд бүртгэж, олон нийтэд ил тод мэдээлнэ.</p>	<ul style="list-style-type: none"> ● Тусгай зориулалтын ойд хэрэгжүүлэх үйл ажиллагааг батлагдсан менежментийн төлөвлөгөө, холбогдох зөвшөөрөлд нийцүүлэн төлөвлөх ● Тусгай зориулалтын ойн менежментийн төлөвлөгөө боловсруулах ● Төлөвлөгөөг ойн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаар батлуулах ● Эзэмшлийн ойд хууль болон улсын, аймаг, сумын төлөвлөгөөнд нийцсэн менежментийн төлөвлөгөө боловсруулах ● Эзэмшлийн ойн менежментийн төлөвлөгөөг эрх бүхий байгууллагаар батлуулах ● Менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах, хяналт тавих ● Төлөвлөгөө ноцтой зөрчигдсэн эсэхийг хянан шалгах ● Зөрчил илэрсэн тохиолдолд төлөвлөгөөг өөрчлөх шаардлага хүргүүлэх ● Хэрэгжилтийг шаардлагатай үед түр түдгэлзүүлэх ● Гэрээний хэрэгжилтийг дүгнэх ● Гэрээг цуцлах шийдвэр гаргах ● Ойн мэдээллийн нэгдсэн системийг хөгжүүлэх, хөтөлөх ● Мэдээллийн санг улсын нэгдсэн стандартын дагуу ажиллуулах ● Ховор, эмзэг, нөхөн төлжилт удаан дагалт баялгийн ашиглалтад хамгаалалт, хязгаарлалт тогтоох

		<ul style="list-style-type: none"> ● Ойн дагалт баялгийн ашиглалтын мэдээллийг бүртгэх ● Мэдээллийг олон нийтэд ил тод, нээлттэй мэдээлэх
	<p>Гэрээт менежментийн явцад байгаль орчинд ноцтой хохирол учруулсан, нөхөн сэргээлтийн үүргийг зөрчсөн, эсхүл орон нутгийн иргэдийн эрх ашигт илт харш нөлөө үзүүлсэн нь тогтоогдсон бол ойн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага гэрээг түдгэлзүүлэх, цуцлах арга хэмжээ авна.</p> <p>Ойн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага болон Ойн агентлаг нь ойн менежмент, ашиглалт, нөхөн сэргээлт, ойжуулалт, дагалт баялгийн ашиглалт, гэрээ, зөвшөөрлийн хэрэгжилтэд мэргэжлийн хяналт-шинжилгээ хийж, нэгдсэн зохицуулалтыг хангана.</p> <p>Сум дундын ойн анги нь ойн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, Ойн агентлагийн мэргэжлийн удирдлагад ажиллана.</p> <p>Ойн анги нь ойн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, Ойн агентлагийн мэргэжлийн удирдлагад ажиллаж, сумын Засаг даргатай хамтран ажиллана.</p> <p>Сангийн хөрөнгийг захиран зарцуулах үйл ажиллагааг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хэрэгжүүлж, ойн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь санхүүжүүлэх арга хэмжээний төлөвлөлт, санал боловсруулах, хэрэгжилтийг зохицуулах, гүйцэтгэлд хяналт-шинжилгээ хийх чиг үүргийг хэрэгжүүлнэ.</p> <p>Ойн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь санхүүжүүлэх арга хэмжээний саналыг ойн менежментийн төлөвлөгөө, ойн нөөцийн үнэлгээ, эрсдэлийн түвшинд үндэслэн боловсруулж хүргүүлнэ.</p> <p>Ойн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:</p> <ul style="list-style-type: none"> - нүүрстөрөгчийн төсөл, бүртгэл, баталгаажуулалтын техникийн санал боловсруулах; - төсөл, арга хэмжээний хэрэгжилт, мониторинг, мэдээллийг нэгтгэх; - орлогын хуваарилалтын шалгуур, тооцоог боловсруулах; - холбогдох мэдээллийг ойн мэдээллийн нэгдсэн системд бүртгэх. 	<ul style="list-style-type: none"> ● Гэрээт менежментийн явцад байгаль орчинд хохирол, зөрчил гарсан эсэхийг хянан тогтоох ● Ноцтой зөрчил илэрсэн тохиолдолд гэрээг түдгэлзүүлэх шийдвэр гаргах ● Шаардлагатай тохиолдолд гэрээг цуцлах арга хэмжээ авах ● Ойн менежмент, ашиглалт, нөхөн сэргээлт, ойжуулалт, дагалт баялгийн ашиглалт, гэрээ, зөвшөөрлийн хэрэгжилтэд мэргэжлийн хяналт-шинжилгээ хийх ● Ойн салбарын үйл ажиллагаанд нэгдсэн зохицуулалтыг хангах ● Сум дундын ойн ангийн үйл ажиллагааг мэргэжлийн удирдлагаар хангах ● Ойн ангийн үйл ажиллагааг холбогдох байгууллагуудтай уялдуулан зохион байгуулах ● Сумын Засаг даргатай хамтран ажиллах, үйл ажиллагааг уялдуулах ● Ойн сангийн хөрөнгийн санхүүжилтийн арга хэмжээг төлөвлөх, санал боловсруулах ● Санхүүжилтийн хэрэгжилтийг зохицуулах, гүйцэтгэлд хяналт-шинжилгээ хийх ● Санхүүжүүлэх арга хэмжээний саналыг ойн менежментийн төлөвлөгөө, нөөцийн үнэлгээ, эрсдэлийн түвшинд үндэслэн боловсруулах ● Нүүрстөрөгчийн төсөл, бүртгэл, баталгаажуулалтын техникийн санал боловсруулах ● Төсөл, арга хэмжээний хэрэгжилт, мониторингийн мэдээллийг нэгтгэх ● Орлогын хуваарилалтын шалгуур, тооцоог боловсруулах ● Холбогдох мэдээллийг ойн мэдээллийн нэгдсэн системд бүртгэх
Ойн агентлаг	<p>Ойн агентлагийн эрх зүйн байдал</p> <p>39 дүгээр зүйл. Ойн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын бүрэн эрх</p>	<ul style="list-style-type: none"> ● Ойн салбарын зохицуулалт, хэрэгжилтийн уялдаа, хяналт-шинжилгээ, мэдээллийн нэгдсэн тогтолцоог хангах

	<p>39.1.Байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний эрхлэх асуудлын хүрээнд ойн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага /цаашид “төрийн захиргааны байгууллага” гэх/, аймаг, нийслэлийн ойн асуудал хариуцсан албан тушаалтан, сумын болон сумын ойн анги /цаашид "ойн анги" гэх/ ажиллана.</p> <p>39.2.Ойн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын үйл ажиллагаа нь нэгдмэл, төвлөрсөн удирдлагатай байна.</p>	<ul style="list-style-type: none"> ● Үйл ажиллагаанд бодлого, зохицуулалт, гүйцэтгэлийг ялгах зарчмыг баримтлах ● Шинжлэх ухаанд суурилсан шийдвэр гаргалтыг хэрэгжүүлэх ● Ил тод, цахим, хариуцлагатай засаглалыг хангах ● Орон нутгийн оролцоог дэмжих ● Салбар дундын уялдааг хангах ● Холбогдох төрийн байгууллага, орон нутгийн байгууллага, мэргэжлийн холбоотой хамтран ажиллах ● Ойн агентлагийн бүтэц, зохион байгуулалтыг Засгийн газрын баталсан хүрээнд хэрэгжүүлэх
	<p>Ойн агентлагийн бүрэн эрх</p> <p>-ойн тогтвортой менежментийн хэрэгжилтийг зохицуулах, уялдааг хангах;</p> <p>-хуульд заасан стандартын төслийг боловсруулж эрх бүхий байгууллагаар батлуулах;</p> <p>-ойн ашиглалт, нөхөн сэргээлт, ойжуулалтын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ хийх; ойн мэдээллийн цахим системийг хөтлөх, хөгжүүлэх;</p> <p>-сумын ойн анги, сум дундын ойн анги, нөхөрлөлд мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж ажиллах;</p> <p>-ойн аж ахуйн арга хэмжээний зураг төсөл, техник, эдийн засгийн үндэслэлд магадлал хийх ажлыг зохион байгуулах, баталгаажуулах;</p> <p>-ойн үрийн улсын нөөцийн сан байгуулах, баяжуулах, үйл ажиллагааг эрхлэх, үржлийн материал бэлтгэх бодлогыг хэрэгжүүлэх;</p> <p>-ойн салбарын бодлого, хууль тогтоомжийг сурталчлах, таниулах;</p> <p>-ойн тооллого, ойн зохион байгуулалт, экологи, эдийн засгийн үнэлгээ хийх аргачлал, зааврыг батлах;</p> <p>-таримал ой бүхий газрыг улсын ойн сан бүхий газарт хүлээн авч, цахим системд бүртгэх;</p> <p>-сумын, сум дундын ойн ангийн үлгэрчилсэн дүрмийг батлах;</p> <p>-мод үржүүлэг, ойжуулалт, ойн нөхөн сэргээлтийн үйл ажиллагаа эрхэлж байгаа иргэн, нөхөрлөл, аж ахуйн нэгжид газар эзэмшүүлэх, санхүүгийн дэмжлэг үзүүлэх, мөнгөн урамшуулал олгох, тэдгээрт шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг тухайн жилийн улсын болон орон нутгийн төсөвт тусгуулж шийдвэрлэх;</p> <p>-ойн нөөцийг хамгаалах, нөхөн сэргээх болон ашиглалтын бүсийн ойд замын хайгуул хийж, зураг, төсөв боловсруулах, ойн төв зам барьж байгуулах ажлыг зохион байгуулах;</p> <p>- хуульд заасан бусад бүрэн эрх.</p>	<ul style="list-style-type: none"> ● Ойн тогтвортой менежментийн хэрэгжилтийг зохицуулах, уялдааг хангах ● Ойн сангийн ангилал, ашиглалтын шийдвэрт мэргэжлийн дүгнэлт гаргах ● Стандарт, аргачлалын хэрэгжилтийг хангах ● Ойн ашиглалт, нөхөн сэргээлт, ойжуулалтын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийх ● Ойн мэдээллийн нэгдсэн системийг хөтлөх, хөгжүүлэх ● Салбарын мэдээлэл, тайлан, ил тод байдлыг хангах ● Ойн эдийн засаг, нүүрстөрөгчийн зах зээлтэй холбоотой бүртгэл, мэдээллийн зохицуулалтыг хэрэгжүүлэх ● Ойн анги, сум дундын ойн анги, ойн нөхөрлөл, хувийн хэвшилд мэргэжлийн зөвлөмж, арга зүйгээр дэмжлэг үзүүлэх

<p style="text-align: center;">Ойн анги</p>	<p>Мод бэлтгэх эрхийн бичгийг тухайн орон нутгийг хариуцсан сум дундын ойн анги цахим системээр олгоно.</p> <p>Ойгоос бэлтгэсэн мод, модон материалыг аймаг, сум, хот, суурины хооронд тээвэрлэх, худалдахдаа гарал үүслийн гэрчилгээтэй байна. Гэрчилгээг тухайн орон нутгийг хариуцсан сум дундын ойн анги цахим системээр олгоно.</p> <p>Ойн анги нь тухайн сумын нутаг дэвсгэрт ойн тогтвортой менежментийг хэрэгжүүлэх анхан шатны гүйцэтгэгч мэргэжлийн байгууллага байна.</p> <p>Ойн анги дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ: -ой хамгаалах, эргүүл, хяналтын үйл ажиллагаа явуулах; -ойжуулалт, нөхөн сэргээлт, арчилгаа, цэвэрлэгээ хийх; -мод бэлтгэлийн талбайг тусгаарлах, тэмдэгжүүлэх; -ойн дагалт баялгийн ашиглалтын бүртгэл хөтлөх, хяналт хэрэгжүүлэх; -ойн нөөц, доройтол, эрсдэлийн мэдээлэл бүрдүүлэх; -ойн нөхөрлөл, иргэн, аж ахуйн нэгжид мэргэжлийн зөвлөмж, арга зүйн дэмжлэг үзүүлэх.</p> <p>Ойн анги нь энэ хууль болон холбогдох хууль тогтоомж, журам, стандарт, аргачлалыг мөрдөнө.</p> <p>Ойн анги нь ойн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, Ойн агентлагийн мэргэжлийн удирдлагад ажиллаж, сумын Засаг даргатай хамтран ажиллана.</p> <p>Ойн ангийн бүтэц, орон тоо, санхүүжилтийн ерөнхий журмыг Засгийн газар батална.</p>	<ul style="list-style-type: none"> ● Мод бэлтгэх эрхийн бичгийг сум дундын ойн ангиас цахим системээр олгох ● Ойгоос бэлтгэсэн мод, модон материалыг тээвэрлэх, худалдахад гарал үүслийн гэрчилгээ шаардах ● Гарал үүслийн гэрчилгээг сум дундын ойн ангиас цахим системээр олгох ● Сумын нутаг дэвсгэрт ойн тогтвортой менежментийг хэрэгжүүлэх ● Ой хамгаалах, эргүүл, хяналтын үйл ажиллагаа явуулах ● Ойжуулалт, нөхөн сэргээлт, арчилгаа, цэвэрлэгээ хийх ● Мод бэлтгэлийн талбайг тусгаарлах, тэмдэгжүүлэх ● Ойн дагалт баялгийн ашиглалтын бүртгэл хөтлөх, хяналт хэрэгжүүлэх ● Ойн нөөц, доройтол, эрсдэлийн мэдээлэл бүрдүүлэх ● Ойн нөхөрлөл, иргэн, аж ахуйн нэгжид мэргэжлийн зөвлөмж, арга зүйн дэмжлэг үзүүлэх ● Холбогдох хууль тогтоомж, журам, стандарт, аргачлалыг мөрдөж ажиллах ● Ойн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, Ойн агентлагийн мэргэжлийн удирдлагад ажиллах ● Сумын Засаг даргатай хамтран ажиллах ● Ойн ангийн бүтэц, орон тоо, санхүүжилтийн батлагдсан журмын дагуу үйл ажиллагаа явуулах
	<p>Сум дундын ойн анги</p> <p>Сум дундын ойн анги нь хоёр ба түүнээс дээш сумын нутаг дэвсгэрт ойн менежментийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх гүйцэтгэгч мэргэжлийн байгууллага байна.</p> <p>Сум дундын ойн анги дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ: -ой хамгаалах, мониторинг, эрсдэлийн хяналт зохион байгуулах; -ойжуулалт, нөхөн сэргээлтийн ажлыг зохион байгуулах; - мод бэлтгэлийн талбайг тусгаарлах, мэргэжлийн дүгнэлт гаргах; -ойн дагалт баялаг, самрын нөөцийн үнэлгээ, ашиглалтын хяналт хэрэгжүүлэх; -ойн тооллого, ой зохион байгуулалтын мэдээлэл бүрдүүлэх; -ойн мэдээллийн нэгдсэн системд мэдээлэл оруулах, шинэчлэх; -ойн анги, орон нутгийн байгууллагад мэргэжлийн арга зүйн дэмжлэг үзүүлэх.</p>	<ul style="list-style-type: none"> ● Хоёр ба түүнээс дээш сумын нутаг дэвсгэрт ойн менежментийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх ● Ой хамгаалах, мониторинг, эрсдэлийн хяналтыг зохион байгуулах ● Ойжуулалт, нөхөн сэргээлтийн ажлыг зохион байгуулах ● Мод бэлтгэлийн талбайг тусгаарлах, мэргэжлийн дүгнэлт гаргах ● Ойн дагалт баялаг, самрын нөөцийн үнэлгээ хийх, ашиглалтын хяналт хэрэгжүүлэх ● Ойн тооллого, ой зохион байгуулалтын мэдээлэл бүрдүүлэх

	<p>Сум дундын ойн анги нь ойн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, Ойн агентлагийн мэргэжлийн удирдлагад ажиллана. Сум дундын ойн анги нь аймаг, сумын Засаг даргатай хамтран ажиллана. Сум дундын ойн ангийн байршил, хамрах хүрээ, бүтэц, санхүүжилтийн ерөнхий журмыг Засгийн газар батална.</p>	<ul style="list-style-type: none"> • Ойн мэдээллийн нэгдсэн системд мэдээлэл оруулах, шинэчлэх • Ойн анги, орон нутгийн байгууллагад мэргэжлийн арга зүйн дэмжлэг үзүүлэх • Ойн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, Ойн агентлагийн мэргэжлийн удирдлагад ажиллах • Аймаг, сумын Засаг даргатай хамтран ажиллах • Байршил, хамрах хүрээ, бүтэц, санхүүжилтийн батлагдсан журмын дагуу үйл ажиллагаа явуулах
--	----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------	----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------

2.2. Хүний нөөцийг тодорхойлох

Хүний нөөцийг тодорхойлохын тулд хуулийн төсөлд тусгасан тухайн шинэ чиг үүргийг хэрэгжүүлэхэд зарцуулах хугацаа болон жилд хэдэн удаа гүйцэтгэх тоо /цаашид “тохиолдлын тоо” гэх/, шаардагдах нийт ажлын цаг гэсэн 3 үзүүлэлтийг тооцож гаргана.

Зарцуулах хугацааг тодорхойлохдоо текст анализын аргад тулгуурлан статистикт тоон мэдээллийг тооцсон болно.

Хүснэгт 7.Стандарт үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд үүсэх хүний нөөцийн хэрэгцээ				
Гүйцэтгэх байгууллага	Стандарт үйл ажиллагаа	Зарцуулах хугацаа	Тохиолдлын тоо	Хүний нөөцийн хэрэгцээ /мин/
Ойн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага	Дүрэм, журам, зааврыг батлах	480	5	2400
	Батлагдсан журам, зааврын хэрэгжилтийг хангах	960	12	11520
	Хэрэгжилтэд хяналт тавих, үнэлгээ хийх	1440	4	5760
	Ойн тухай хуулийн үүргийн хэрэгжилтэд хяналт тавих	960	6	5760
	Хэрэгжилтийг хангах, шаардлагатай арга хэмжээ авах	720	6	4320
	Холбогдох журам, заавар, төлөвлөгөөг батлах, шинэчлэх	1440	3	4320
	Хяналт шалгалтын үйл ажиллагааг зохион байгуулах	1440	6	8640
	Хяналт шалгалтын үр дүнг тайлагнах	960	4	3840
	Ашиглалтын хэмжээг бууруулах	240	1	240
	Ашиглалтыг түр зогсоох	480	1	480
	Ойн ангиллыг өөрчлөх	1440	2	2880
	Нөхөн сэргээлтийн тусгай дэглэм тогтоох	240	1	240
Ойн нөөцийн талаарх суурь мэдээлэл цуглуулах	1440	2	2880	

Ашиглах нөөцийн дээд хэмжээг тогтоох	480	3	1440
Экосистемийн даацын үнэлгээ хийх	60	100	6000
Хэрэгжилтэд тогтмол хяналтшинжилгээ хийх	10000	10	100000
Гэрээний хэрэгжилтийг дүгнэх	10000	5	50000
Менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах, хяналт тавих	5	5000	25000
Шийдвэрийг хэрэгжүүлэх, олон нийтэд мэдээлэх	480	2	960
Цахим мэдээллийн аюулгүй байдлыг хангах	960	12	11520
Техник, системийн шинэчлэл, тохиргоог тогтмол хийх	1440	4	5760
Мэдээллийн аюулгүй байдлыг хангах арга хэмжээ хэрэгжүүлэх	720	12	8640
Ховор, эмзэг, нөхөн төлжилт удаан дагалт баялгийн ашиглалтад хамгаалалт, хязгаарлалт тогтоох	1440	2	2880
Ойжуулалтын сангийн үйл ажиллагаа, /төсөвлөх, зарцуулалтыг зохион байгуулах, төсөл сонгон шалгаруулах, тайлагнах/	1440	260	374,400
Нүүрс төрөгчийн сангийн үйл ажиллагаа /төсөвлөх, зарцуулах, хяналт тавих, сонгон шалгаруулах, тайлагнах/	1440	260	374,400
Нийт			1,056,000
Ойн салбарын зохицуулалт, хэрэгжилтийн уялдаа, хяналт-шинжилгээ, мэдээллийн нэгдсэн тогтолцоог хангах	1440	360	518,400
Ил тод, цахим, хариуцлагатай засаглалыг хангах	960	3	2880
Холбогдох төрийн байгууллага, орон нутгийн байгууллага, мэргэжлийн холбоотой хамтран ажиллах	1440	260	374,400

Ойн агентлаг	Ойн агентлагийн бүтэц, зохион байгуулалтыг Засгийн газрын баталсан хүрээнд хэрэгжүүлэх	10	2	20
	Ойн тогтвортой менежментийн хэрэгжилтийг зохицуулах, уялдааг хангах	5	10	50
	Ойн сангийн ангилал, ашиглалтын шийдвэрт мэргэжлийн дүгнэлт гаргах	60	2	120
	Стандарт, аргачлалын хэрэгжилтийг хангах	40	3	120
	Ойн ашиглалт, нөхөн сэргээлт, ойжуулалтын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийх	90	5	450
	Ойн мэдээллийн нэгдсэн системийг хөтлөх, хөгжүүлэх	90	3	270
	Салбарын мэдээлэл, тайлан, ил тод байдлыг хангах	150	2	300
	Ойн эдийн засаг, нүүрстөрөгчийн зах зээлтэй холбоотой бүртгэл, мэдээллийн зохицуулалтыг хэрэгжүүлэх	399	10	3990
	Ойн анги, сум дундын ойн анги, ойн нөхөрлөл, хувийн хэвшилд мэргэжлийн зөвлөмж, арга зүйгээр дэмжлэг үзүүлэх	590	100	59000
Нийт			960,000	
Ойн анги	Мод бэлтгэх эрхийн бичгийг сум дундын ойн ангиас цахим системээр олгох	240	30000	7,200,000
	Гарал үүслийн гэрчилгээг сум дундын ойн ангиас цахим системээр олгох	120	15000	1,800,000
	Ойн дагалт баялгийн ашиглалтын бүртгэл хөтлөх, хяналт хэрэгжүүлэх	60	200	12000
	Ойн нөхөрлөл, иргэн, аж ахуйн нэгжид мэргэжлийн зөвлөмж, арга зүйн дэмжлэг үзүүлэх	250	10000	2,500,000

Ойн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, Ойн агентлагийн мэргэжлийн удирдлагад ажиллах	20	200	4000
Сумын Засаг даргатай хамтран ажиллах	40	150	6000
Ойн ангийн бүтэц, орон тоо, санхүүжилтийн батлагдсан журмын дагуу үйл ажиллагаа явуулах	250	300	75000
Хоёр ба түүнээс дээш сумын нутаг дэвсгэрт ойн менежментийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх	120	10000	120000
Ой хамгаалах, мониторинг, эрсдэлийн хяналтыг зохион байгуулах	100	300	30000
Ойжуулалт, нөхөн сэргээлтийн ажлыг зохион байгуулах	360	10000	3,600,000
Мод бэлтгэлийн талбайг тусгаарлах, мэргэжлийн дүгнэлт гаргах	30	150	4500
Ойн дагалт баялаг, самрын нөөцийн үнэлгээ хийх, ашиглалтын хяналт хэрэгжүүлэх	120	1000	120000
Ойн тооллого, ой зохион байгуулалтын мэдээлэл бүрдүүлэх	150	10000	1,500,000
Ойн мэдээллийн нэгдсэн системд мэдээлэл оруулах, шинэчлэх	60	100	6000
Ойн анги, орон нутгийн байгууллагад мэргэжлийн арга зүйн дэмжлэг үзүүлэх	60	30	1800
Ойн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, Ойн агентлагийн мэргэжлийн удирдлагад ажиллах	60	50	3000
Аймаг, сумын Засаг даргатай хамтран ажиллах	15	100	1500
Байршил, хамрах хүрээ, бүтэц, санхүүжилтийн батлагдсан журмын дагуу үйл ажиллагаа явуулах	20000	221	4,419,000
Нийт			21,402,800

Нийт зарцуулах хугацаа

23,418,800

Шаардагдах ажлын цагийг Хөдөлмөрийн тухай хуульд заасан ажиллах цагийн горимтой харьцуулан авч үзнэ. Ингэхдээ нэг жилд ажиллах өдөр, цаг, минут гэсэн хэмжигдэхүүнд тулгуурлана.

1 жил = ажлын 200 өдөр
 1 өдөр = ажлын 8 цаг /Хөдөлмөрийн тухай хуулийн дагуу/
 1 цаг = ажлын 60 минут

Жилд 200 ажлын өдөр буюу (200 x 8) 1.600 ажлын цаг буюу (1.600 x 60) 96.000 минут ажиллана.

Нийт зарцуулах хугацаагаар хүний нөөцийн хэрэгцээ тодорхойлогдох ба тэрхүү хугацааг жилд ажиллах ажлын минутад хувааснаар шаардлагатай хүний нөөц буюу нэмэгдэх орон тоо гарна.

Хүснэгт 8.Төрийн байгууллагын нэмэгдэж буй хүний нөөцийн ачаалал

Нэгж	Хүний нөөцийн хэрэгцээ /мин/	Жилд шаардагдах ажлын цаг /мин/	Нэмэгдэж буй ачаалал /хүний тоо/
Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага /2 сангийн үйл ажиллагаатай холбоотой/	480,000	96000	5
Ойн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага /шинэ чиг үүрэг болон мэдээллийн сангийн үйл ажиллагааны чиг үүрэг нэмэгдсэнтэй холбоотойгоор/	393600	96000	4.1
Ойн анги /шинэ чиг үүрэг нэмэгдэхээс гадна, ангилал шатлал өөрчлөхтэй холбоотой/	24,402,000	96000	230

Ойн тухайн хуулийн шинэчилсэн найруулгын төслийг хэрэгжүүлэхэд байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага менежментийн төлөвлөгөө боловсруулах, санал авах, батлуулах, 2 сангийн удирдлага зохион байгуулалт, хэрэгжүүлэх, хяналт тавих, тайлагнахтай холбоотой чиг үүрэгт 5, ойн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага менежментийн төлөвлөгөө боловсруулах, хэрэгжилтэд хяналт тавих, тусгай зориулалтын ойн удирдлага зохицуулалт, мэдээллийн санг өргөжүүлэхтэй холбоотой 4.1, ойн ангийн одоо байгаа орон тоон дээр ажиллагаа байгаа 230 албан хаагчийн ангилал, шатлалыг өөрчлөхтэй холбоотойгоор төсөвт үүсэх ачаалал нэмэгдэж байна.

2.3. Гарах зардлыг урьдчилан тооцох

Хуулийн төсөлд улсаас төсөвт үүсэх зардал, төрийн байгууллагын ачааллыг тооцохдоо аргачлалд заасны дагуу хүний нөөцийн зардлыг юун түрүүнд тооцно.

Нэг албан хаагчид зарцуулах, төрөөс даах зардлыг тооцохдоо түүнд олгох үндсэн цалингаас гадна (1) бүх төрлийн даатгал, (2) хоол, унааны нэмэгдэл, (3) ажилласан жилийн нэмэгдэл, (4) зэрэг, дэвийн нэмэгдэл, (5) буцалтгүй тусламж, (6) шагнал, урамшуулал, нийгмийн даатгалын шимтгэл зэрэг нэмэлт зардлыг нэмж тооцох шаардлагатай байдаг.

Төрийн албан хаагчийн цалингийн зардлыг тооцоходоо төрийн захиргааны, төрийн үйлчилгээний, төрийн үйлчилгээний мэргэжлийн гэсэн ангилал зэрэглэлийг тухай албан хаагчийн тохирох шатлал, зэрэглэлд тус бүр тооцон сарын, жилийн хүний нөөцийн зардлыг тооцсон болно.

Тус хуулийн төслийн 41 дүгээр зүйлийн 41.1-д “Ойн агентлаг нь ойн салбарын зохицуулалт, хэрэгжилтийн уялдаа, хяналт-шинжилгээ, мэдээллийн нэгдсэн тогтолцоог хангах чиг үүрэг бүхий тохируулагч агентлаг байна” гэж тусгасан байна. Үүнээс гадна ойжуулалтын сан, нүүрстөрөгчийн сангийн удирдлагын чиг үүргийг байгаль орчны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага буюу яаманд хариуцуулахаар хуулийн төсөлд тусгасантай холбоотойгоор чиг үүрэг нэмэгдэх тул хүний нөөцийн зардал гарах ба төрийн захиргааны албан хаагчийн цалингийн хэмжээг хэд хэдэн хувилбартайгаар бодож доод тал нь 15.2 хүний орон тоо нэмэгдэхээр тооцоологдож байна.

Хүснэгт9.Төрийн байгууллагын нэмэгдэж буй хүний нөөцийн ачаалал

Байгууллага	Хүний тоо
Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага /улсын менежментийн төлөвлөгөөг боловсруулах, санал авах, тусгай зориулалтын ойн дэглэмийг хэрэгжүүлэх, Засгийн газраар батлуулах, 2 сангийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулахтай холбоотой/	5
Ойн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага /шинэ чиг үүрэг, мэдээллийн сангийн үйл ажиллагааны чиг үүрэг нэмэгдсэнтэй холбоотойгоор/	4.1
Ойн анги	-

Энэ зардал дээр тооцож гаргасан **хүний нөөцийн хэрэгцээнд** үржүүлж хүний нөөцийн нийт зардал гарна. Дээрх хүснэгтэд нэмэгдэж буй хүний нөөцийг тодорхойлсон тул ойн ангид хүний орон тоог нэмэхгүй бөгөөд харин ангилал зэрэглэлийг өөрчлөх байдлаар цалинг нэмэгдүүлэх юм. Иймд дээр хүснэгтэд тооцоогүй бөгөөд цалингийн тооцооллын хүснэгтэд хувилбартайгаар тооцсон болно.

Хүснэгт 10.Төрийн байгууллагын нэмэгдэж буй хүний нөөцийн цалингийн зардал төг

Нэгж	Нэмэгдэж буй ачаалал /хүний тоо/	Нэг албан хаагчийн 1 жилийн цалингийн зардал /төг/	Хүний нөөцийн зардал /төг/
Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага	5	220,887,630	263,279,430
/улсын менежментийн төлөвлөгөөг боловсруулах, санал авах, Засгийн газраар батлуулах, 2 сангийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулахтай холбоотой/			
Ойн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага /тусгай зориулалтын ойн дэглэмийг хэрэгжүүлэх, мэдээллийн сангийн үйл	3.1	37,681,600	158,262,720

ажиллагааны чиг үүрэг нэмэгдсэнтэй холбоотойгоор/			
ТЗ ангиллаар тооцох			
Ойн анги	46 /ТҮМ-7 дарга/ 184 /ТҮМ-6 мэргэжилтэн/	42,569,800/дарга/ 34,048,560 /мэргэжилтэн/ 86,195,655 /нийлбэр НДШ 12% хамт/	9,251,039,070
ТЗ болон ТҮМ ангиллаар тооцох			
Ойн анги	46/ТЗ-5 дарга/ 184 /ТҮМ-6 мэргэжилтэн/	36,344,320 /дарга/ 34,048,560/мэргэжилтэн/ 90,441,990 /нийлбэр НДШ 12% хамт/	9,446,370,480

Ойн тухайн хуулийн шинэчилсэн найруулгын төслийг хэрэгжүүлэхэд байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага 263,279,430 төгрөг /дарга 1, ТЗ-2, ахлах шинжээч 1, ТЗ-4, шинжээч 1 ТЗ-5, мэргэжилтэн 2 ТЗ-7 тооцсон/, ойн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага 158,262,720, ойн ангийн дарга мэргэжилтний ангилал зэрэглэлийг Сав газрын дарга, мэргэжилтний ТЗ-5 ангилал зэрэглэлтэй дүйцүүлэн тооцоход жилд 466,982,570 төгрөг, харин ойн ангийн дарга, мэргэжилтнийг ТЗ-5, ТҮМ-6 ангиллаар тооцоход жилд 9,446,370,480 төгрөг буюу улсын төсвөөс нэмэлтээр 3,142,105,785 төгрөгийн хүний нөөцийн зардал гарахаар байна. Ойн ангийн албан хаагчийн цалинг нэмэгдүүлэхтэй холбоотойгоор дараагийн бүлэгт тодорхой хувилбартай зардлыг тооцож гаргасан болно.

2.4. Үр дүнг тооцох

Хүний нөөцийн дундаж зардал, материаллаг дундаж зардал, бусад зардлыг нэмснээр нийт зардал гарна.

Материаллаг зардал гэж тухайн ажлын байртай холбогдон гарах нийтлэг зардлыг хэлнэ. Үүнд, ажлын байр, (түрээсэлдэг бол түрээсийн төлбөр, төрийн эзэмшлийн эд хөрөнгө бол элэгдэл хорогдлын зардал), цахилгаан дулаан, бичиг хэргийн зардал, техник, тоног төхөөрөмжийн зардал, урсгал зардал, хөрөнгө оруулалтын зардал гэх мэт орно.

Төрийн байгууллагын нэг ажилтанд ногдох материаллаг зардлыг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолоор батлагдсан “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлал”-ын хавсралтыг үндэслэж, нэмэгдсэн ажлын байранд оногдох тоног төхөөрөмж, бичиг хэргийн зардал зэрэг 1 албан хаагчид оногдох материаллаг зардлыг дараах байдлаар ерөнхийлөн тооцоо.

Хүснэгт 11.Нэг албан хаагчид оногдох материаллаг зардал /төг/

Зардлын төрөл	Зардлын нэр	Зардал /төг/
Урсгал зардал	Бичиг хэргийн зардал	121,285
	Шуудан холбоо	167,881
	Компьютер, тоног төхөөрөмж	3,351,757

Зардал	Тавилга, эд хогшил	53,725
	Түлш, халаалт	199,897
	Гэрэл, цахилгаан	937,251
	Цэвэр, бохир ус	51,947
	Урсгал засвар	53,725
Элэгдэл, хорогдлын зардал	Газрын төлбөр	1,411
	Техник, тоног төхөөрөмж	356,555
	Тавилга, эд хогшил	100,000
Нэг албан хаагчид оногдох		5,395,434

Нэг албан хаагчид оногдох зардлыг тооцохдоо урсгал зардал болон зардал, элэгдэл, хорогдлын зардлын хамтад нь тооцсон бөгөөд нэг албан хаагчид оногдох зардлыг 5,395,434 /таван сая гурван зуун ерөн таван мянга дөрвөн зуун дөчин дөрвөн төгрөг/ байхаар тооцлоо.

Хүснэгт 12.Материаллаг зардал /төг/		
Нэгж	Хүний тоо	Материаллаг зардал /төг/
Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага /улсын менежментийн төлөвлөгөөг боловсруулах, санал авах, Засгийн газраар батлуулах, 2 сангийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулахтай холбоотой/	5	26,977,170
Ойн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага /бусад чиг үүрэг болон мэдээллийн сангийн үйл ажиллагааны чиг үүрэг нэмэгдсэнтэй холбоотойгоор/	3.1	16,725,845
Ойн анги	230	-
Нийт зардал		43,703,015

Дээрх материаллаг зардалд ойн ангийн нийт 230 албан хаагчийн ангилал зэрэглэлийг өөрчлөн цалинг нэмэгдүүлэх хүрээнд эрх зүйн байдлыг дээшлүүлж байгаатай холбоотой цалингийн зардлын өөрчлөлт орохоос шинээр орон тоо нэмэгдэхгүй тул материаллаг зардал гарахгүй гэж үзсэн.

Түүнчлэн хуулийн төсөлд тусгасан зөвшөөрлийг цахимаар өгөхтэй холбоотой урсгал зардал нэмэгдэхгүй гэж үзсэн. Иймд дээрх материаллаг зардлын хүснэгтэд Ойн газарт шинээр чиг үүрэг нэмэгдэж байгаатай уялдан шинээр нэмэгдэх хүний тооны материаллаг зардлыг тооцсон болно.

2.4.1. Мэдээллийн сан

Ойн мэдээллийн нэгдсэн систем хөгжүүлэлтийн талаар хуулийн 47 дугаар зүйлийн 47.4 -т зааснаар Ойн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага ойн, ойн баялгийн нөөц, түүний ашиглалт, хамгаалалт, нөхөн сэргээлт, менежменттэй холбоотой мэдээллийг бүрдүүлэх, бүртгэх,

хадгалах, боловсруулах, солилцох, ашиглах зорилгоор улсын хэмжээний ойн мэдээллийн цахим систем ажиллуулна.гэж, мөн зүйлийн 47.3-т “Ойн мэдээллийн цахим системд дараах мэдээллээс бүрдэнэ:

- 47.3.1.ойн бүсийн ангилал, хил зааг, байршил, талбай;
- 47.3.2.ойн тооллого, ой зохион байгуулалтын мэдээлэл;
- 47.3.3.ойн менежментийн төлөвлөгөө (улсын, аймаг, нийслэл, сум);
- 47.3.4.зөвшөөрөл, гэрээ, ашиглалтын эрхийн мэдээлэл;
- 47.3.5.мод бэлтгэл, ойн дагалт баялаг, самрын ашиглалтын бүртгэл;
- 47.3.6.ойжуулалт, нөхөн сэргээлт, арчилгаа, хамгаалалтын арга хэмжээ;
- 47.3.7.ойн нүүрстөрөгч шингээлт, ялгаралтын бүртгэл, зах зээл, төслийн мэдээлэл;
- 47.3.8.түймэр, хөнөөлт организм, байгалийн гамшгийн мэдээлэл;
- 47.3.9.хяналт шалгалт, зөрчил, авсан арга хэмжээний мэдээлэл;
- 47.3.10.ойн туршилт, судалгааны байнгын болон түр талбайн байршил, арчилгааны

мэдээлэл;

47.3.11.нөхөрлөлийн үйл ажиллагаа, гэрээ, тайлан, талбайн мэдээлэл;

47.3.12.сонгон шалгаруулалтын мэдээлэл, гэрээ, талбайн хил зааг, хүлээх үүрэг, хөрөнгө оруулалт, тайлангийн мэдээлэл;

47.3.13.хөрөнгө оруулалтын төсөл, санхүүжилтийн мэдээллийг

47.3.14.хуульд заасан бусад мэдээлэл.” гэж тус тус тусгасан байдгаас үзэхэд үүнтэй холбоотой системийн хөгжүүлэлт, талаар зардал гарахаар байна. Тодруулбал, одоо байгаа ойн мэдээллийн санд дээрх дурдсан мэдээллээс зарим мэдээлэл нэмэлтээр орох байна. Иймд ойн мэдээллийн сангийн программыг хуулийн төсөлд дурдсан нэмэлт мэдээлэл агуулах шаардалгыг хангах зөөлөн дэд бүтцийн хөгжүүлэлтийг хийхэд дунджаар ойролцоогоор 50,000,000³ сая төгрөг байхаар тооцоолов.

Түүнчлэн Ойн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн хүрээнд 19 дүгээр зүйлийн 19.10 дахь хэсэгт “19.10.Иргэн, хуулийн этгээд нь өөрийн хөрөнгөөр тарьж ургуулсан ой, модыг ойгоор бүртгүүлэх хүсэлтээ сумын болон сум дундын ойн ангид цахимаар гаргана.” гэж, 30 дугаар зүйлийн 30.3 дахь хэсэгт “Ойн үр, үржлийн материалын гарал үүслийн гэрчилгээг ойн анги цахимаар олгоно.” тус тус тусгаснаас үзэхэд зөвшөөрөл олголтыг цахимаар явуулахаар тусгасан байна. Иймд тус цахимаар зөвшөөрөл олголтыг хийх техникийн нөхцөлийг хангахад нэг удаагийн зардлыг дунджаар 250 000 000⁴ төгрөгийг зардал гарахаар байна. Энэхүү дүнд хатуу болон зөөлөн дэд бүтцийг шийдвэрлэх программ хангамж, сервер, сүлжээний компьютер зэрэг орохоор тооцсон болно.

Харин Засгийн газрын чиг үүргийн дагуу журам,загвар гэрээг батлах тул хүний нөөцийн зардал үүсэхгүй байна.

Төрөөс ойн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дараах чиглэлээр дэмжиж болно гээд технологийн шинэчлэл, стандартын баталгаажуулалт, гарал үүслийн хяналт, мөрдөн хянах тогтолцоо, орон нутгийн жижиг, дунд, үйлдвэрлэл, хоршоог дэмжих, экспортын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, татварын бодлогоор дэмжих гэж зохицуулсан нь дэмжлэг хийхэд тодорхой, төсөв, зардал гарах боловч гол асуудал нь тодорхойгүй байгаа тул зардлыг тодорхойлох боломжгүй байна. Мөн дагах хуулийн төсөлд татварын хууль тогтоомжид татвараас чөлөөлөхтэй холбоотой хуулийн төсөл байхгүй байна

2.4.2. Ойжуулалтын сан болон Нүүрстөрөгчийн сан

Ойн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн 49 дүгээр зүйлийн 49.1 дэх хэсэгт “Ойн баялгийг хамгаалах, нөхөн сэргээх, ойжуулах, мониторинг хийх, ойн тооллого, ой зохион байгуулалт, ойн мэдээллийн цахим системийн хэвийн үйл ажиллагааг хангах, орон нутгийн оролцоог дэмжих,

³ <https://user.tender.gov.mn/mn/index/>

⁴ <https://user.tender.gov.mn/mn/index/>


салбарын тогтвортой санхүүжилтийг бүрдүүлэх зорилгоор ойжуулалтын сантай байна.” гэж, 51 дүгээр зүйлийн 51.1 дэх хэсэгт “51.1.Ойн нүүрстөрөгчийн шингээлт, ялгаралтай холбоотой төсөл, бүртгэл, баталгаажуулалт, орлогын хуваарилалт, зах зээлийн оролцоог дэмжих зорилгоор Нүүрстөрөгчийн сантай байж болно.” гэж тус тус тусгасан байна.

Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 84 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан "Төрийн үйлчилгээний бусад байгууллага болон төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад туслах албан тушаалын зэрэглэл, түүнд хамаарах албан тушаалын жагсаалт"-ын дагуу Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 128 дугаар тогтоолын 11 дүгээр хавсралтын дагуу цалингийн санг тооцооллоо.

Цалингийн зардлыг тооцохдоо үндсэн цалингаас гадна хоол, унааны нэмэгдэл, ажилласан жилийн нэмэгдэл, зэрэг дэвийн нэмэгдэл, буцалтгүй тусламж, шагнал урамшуулал зэрэг нэмэгдэл зардлыг тооцох шаардлагатай ба эдгээрийг нарийвчилж тогтоох боломжгүй тохиолдолд нэг албан хаагчийн цалингийн дундаж хэмжээний 15 хувиар нийтлэг зардлыг, 10 хувиар дагалдах зардлыг, 30 хувиар нэмэгдэл, урамшууллын зардлыг тооцох боломжтой⁵.

Засгийн газрын тусгай сангаас жишиг болгон Шинжлэх Ухаан Технологийн сангийн бүтэц зохион байгуулалтыг авч үзвэл нийт 24 хүний орон тоотой байна.

Зураг 2.Шинжлэх ухаан технологийн сангийн бүтцийн жишээ



Ойжуулалтын санг 5 хүнтэйгээр тооцож байгуулахад доор дурдсан зардал гарах ба Нүүрс төрөгчийн сан болон Ойжуулалтын санг нэгтгэн нэг ажлын албатай байхаар тооцбол зардал багасах юм. Харин тус тусдаа сан байвал адил бүтэцтэйгээр ТҮ ангиллаар тооцоолоход нийт 624,065,850 төгрөгийн зардал төрд учрахаар байна.

Хүснэгт 13.Цалингийн сангийн тооцоо, /төг/

№	Албан тушаал	орон тоо	Ангилал	Үндсэн цалин/төг/	Үндсэн цалин /сар.төг/	Үндсэн цалин /жил.төг/	бусад /55%/	Нийт цалингийн сан /төг/
1	Дарга	1	ТҮ-11	1,621,000	1,621,000	19,452,000	10,698,600	30,150,600

⁵ Хууль зүйн үндэсний хүрээлэн, Хууль зүйн судалгааны төв Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын хуулийн төсөлд хийсэн зардлын тооцооны тайлангаас жишиг болгон авав.

3	Мэргэжилтэн	4	ТҮ-8	1,337,000	5,348,000	64,176,000	35,296,800	99,472,800
Нийт дүн		5						120,623,400
				НДШ 12.5				16,202,925
				Нийт зардал				136,826,325

Хувилбар 2 /Төрийн захиргааны төв байгууллагын албан хаагчтай дүйцүүлэн ТЗ ангиллаар тооцоход/

Ойжуулалтын сангийн ажлын албыг 5 хүнтэйгээр албан хаагчдыг ТЗ ангиллаар тооцоход нийт 263,279,430 төгрөгийн зардал, харин 2 санг тус тусдаа ажлын албатай байхаар тооцвол 526,558,860 төгрөгийн цалингийн зардал төрд жилд учрахаар байна.

Хүснэгт 14.Цалингийн сангийн тооцоо, /төг/

№	Албан тушаалын зэрэглэл	Үндсэн цалин /төг/	Сарын нийт цалин /төг/	Улирлын үр дүнгийн урамшуулал 50%	Улирлын үр дүн орсон цалин /төг/	Жилийн нийт цалин хөлс /1 хүн/ /төг/	Нийт дүн /11 хүн/ /төг/
1	Дарга ТЗ-2 /1 хүн/	2,974,000	4,639,440	1,487,000	6,126,440	61,621,280	61,621,280
2	Ахлах шинжээч ТЗ-4 /1 хүн/	2,646,000	3,783,780	1,323,000	5,106,780	50,697,360	50,697,360
3	Шинжээч ТЗ-5 /1 хүн/	2,497,000	3,445,860	1,248,500	4,694,360	46,344,320	46,344,320
4	Мэргэжилтэн ТЗ-8 /2 хүн/	2,141,000	2,783,300	1,070,500	3,853,800	37,681,600	75,363,200
Нийт дүн		10,258,000	14,652,380	5,129,000	19,781,380	196,344,560	234,026,160
							НДШ 12.5%
							29,253,270
							Нийт зардал
							263,279,430

Дээрх цалингийн зардлыг тооцохдоо албан хаагчийн албан хаасан нэмэгдэл, зэрэг дэвийн нэмэгдэл зэргийг дараах байдлаар тооцсон болно. Үүнд:

Хүснэгт 15. Албан хаасны болон зэрэг дэвийн нэмэгдлийн хувь хэмжээ /хувь/

№	Албан тушаалын зэрэглэл	Алба хаасан нэмэгдэл хувь	Зэрэг дэв /хувь/	Нийт хувь хэмжээ/хувь/
1	Дарга ТЗ-2 /1 хүн/	20%	36%	56%

2	Ахлах шинжээч ТЗ-4 /1 хүн/	15%	28%	43%
3	Шинжээч ТЗ-5 /1 хүн/	10%	28%	38%
4	Мэргэжилтэн ТЗ-8 /2 хүн/	10%	20%	30%

Аргачлалын дагуу цалингийн зардлаас гадна материаллаг зардал буюу ажлын байртай холбоотой зардлыг тооцох шаардлагатай. Ажлын байрыг түрээслэхээр тооцооллыг хийлээ.

Иймд нүүрстөрөгчийн сан болон ойжуулалтын санг адил бүтэцтэй тус тусад нь байгуулах тохиолдолд 118,699,548 төгрөгийн түрээсийн материаллаг зардал гарахаар байна.

Нэгдүгээр хувилбарын дагуу тооцож үзэхэд хүний нөөц, материаллаг зардал 371,382,699 төгрөгийн зардал, харин хоёрдугаар хувилбарын дагуу тооцож үзэхэд хүний нөөцийн болон материаллаг зардалд 576,980,004 төгрөг ойролцоогоор тооцоологдов.

Хүснэгт 16. Хүний нөөцийн болон материаллаг зардал /төг/

		Хүний нөөц /төг/	Материаллаг /төг/	Нийт /төг/
1	Хувилбар 1 /ТҮ/	136,826,325	26,977,170	163,803,495
2	Хувилбар 2 /ТЗ/	263,279,430	26,977,170	290,256,600

Хуулийн төслийн 50 дугаар зүйлийн 50.1 дэх хэсэгт зааснаар ойжуулалтын сан дараах эх үүсвэрээс бүрдэнэ гээд ойн баялгийн нөөц ашигласны төлбөр; олон улсын хөтөлбөр, төсөл, буцалтгүй тусламж, хандив; нүүрстөрөгчийн зах зээл, экосистемийн үйлчилгээний орлого; ойн баялагт учирсан хохирлын нөхөн төлбөр; хуульд нийцсэн бусад эх үүсвэрийг оруулсан байна. Эдгээр эх үүсвэрээс ойн нөөц ашигласны төлбөрийн орлого энэхүү санд орохоор заасан орон нутгийн төсөвт орох хөрөнгө ойжуулалтын санд орохоор заасан байна. Тодруулбал, байгаль орчны нөөц ашигласны жилийн орлогын 4-6.1 хувь буюу дунджаар 7 тэрбум нь ойн нөөц ашигласны төлбөр ордог байна. Иймд дунджаар жилд 7 тэрбум төгрөг ойжуулалтын санд орох бөгөөд орон нутгийн сангаас энэ хэмжээний дүнгийн 85 хувь нь хасагдах юм.

2.4.3. Ойн анги

Ойн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн 19 дүгээр зүйлийн 19.10, 30 дугаар зүйлийн 30.3 дахь хэсэгт ойн анги нь цахимаар зөвшөөрөл, гарал үүслийн гэрчилгээ олгох, тарьсан ойг бүртгүүлэх зэрэг үйл ажиллагааг сумын эсхүл сум дундын ойн анги цахим системээр олгохоор тусгасан нь төрд буюу ойн ангил зардал гарахаар байна. Энэхүү зардал нь одоо хийгдэж байгаа урсгал зардалд бүрэн багтах бөгөөд харин бичиг хэргийн зэрэг материаллаг зардлыг хэмнэхээр байна.

Харин ойн ангийн дарга, мэргэжилтний эрх зүйн байдлыг нэмэгдүүлэх хүрээнд ангилал зэргэллийг өөрчилж, цалингийн хэмжээг нэмэгдүүлэх хуулийн төслийн үзэл баримтлалд заасан зорилтын дагуу ойн ангийн албан хаагчийн ангилал, цалингийн шатлалыг өөрчлөн 2 хувилбараар тооцон үзлээ.

2.4.3.1. Ойн ангийн одоогийн албан хаагчийн шатлал, зэрэглэл, цалин

Судалгаагаар нийт 46 ойн анги, сум дундын ойн анги үйл ажиллагаагаа явуулж байгаа бөгөөд эдгээрээс дийлэнх нь буюу 26 ойн ангийн дарга ТҮ-9, мэргэжилтэн ТҮ-8, төрийн захиргааны бусад байгууллагын албан тушаалын ангилал зэрэглэл, цалингийн сүлжээнд хамрагдаж байна. Иймд ангилал шатлалын дагуу дараах дундаж тооцооллыг гаргав. Иймд ангилал шатлалын дагуу дараах дундаж тооцооллыг гаргав. Үүнд:

Хүснэгт 17. Ойн ангийн албан хаагчийн ТҮ-9, ТҮ-8 шатлалын цалингийн дундаж тооцоо /төг/

№	Ажлын байр (ТҮ)	Цалин /төг/	Орон тоо	Сард /төг/	Жилд нийт /төг/
1	Ойн ангийн дарга	2,759,023	46	126,915,069	1,522,980,696
2	Мэргэжилтэн	1,842,100	184	454,970,360	5,459,644,329
3	Нийт цалингийн зардал	-	-	581,855,429	6,982,625,157
		НДШ 12.5%			872,828,144
		НИЙТ			7,855,453,301

ТҮ-9 үндсэн цалин 2,060,455 төгрөг бөгөөд ур чадвар /25 хувь/, удаан жил /дунжаар 15 хувь/ийн нэмэгдлийн хамт ойн ангийн дарга дунджаар 2,759,023 төгрөгийн цалин авах бөгөөд нийт 46 ойн ангиар тооцоход нийт 126,915,069 төгрөг сард зарцуулахаар байна. Харин мэргэжилтэн ТҮ-8 үндсэн цалин 1,842,100 төгрөг бөгөөд ур чадвар /25 хувь/, удаан жил /15 хувь/-ийн нэмэгдлийн хамт сард дунджаар 2,472,665 төгрөг буюу нийт 184 ойн ангийн мэргэжилтэн байна гэж тооцоход сард дунджаар 454,970,360 төгрөг, жилд дунджаар 7,855,453,301 төгрөгийн төсөв зарцуулж байна.

Энэхүү тооцоонд докторын зэрэг болон хоол унааны мөнгө, улирал хагас бүтэн жилийн үр дүнгийн урамшууллын тооцоогүй болно. Нийт ойн ангийн зардал сард 584,885,429 төгрөг байна.

2.4.3.2. Хуулийн төсөл, төслийн үзэл баримтлалын дагуу тооцсон ойн ангийн албан хаагчийн шатлал, зэрэглэл, цалин

Хувилбар 1.

Хуулийн төслийн үзэл баримтлал, төсөл, танилцуулгад тусгасны дагуу ТҮ-ийн ангилал зэрэглэлээс ТЗ ангилал зэрэглэлд ойн ангийн дарга, мэргэжилтнийг шилжүүлэхээр дурдсан бөгөөд ойн анги нь сумын түвшинд ажилладаг тул сав газрын ТЗ албан тушаалын ангилал зэрэглэлтэй дараах байдлаар дүйцүүлэн үзлээ.

Ойн ангийн дарга ТЗ-8, үндсэн цалин 1,608,850 төгрөг /үүнд Засгийн газрын 2025 оны дугаар тогтоолын дагуу 15 хувийн цалингийн нэмэгдэл орсон дүн/, удаан жил /15 хувь/, зэрэг дэв /20 хувь/ нийт сарын цалин 2,171,947 төгрөг бөгөөд 46 ойн ангийн даргаар тооцоход сард нийт 99,909,562 төгрөг болно. Харин мэргэжилтнийг ТЗ-9 ангилалд дүйцүүлэн тооцоход үндсэн цалин 1,477,750 төгрөг, удаан жил /15 хувь/, зэрэг дэв /20 хувь/ сард нийт 1,994,962 төгрөг буюу нийт 184 мэргэжилтэн байхаар тооцоход 367, 073,008 төгрөгийн зардал сард гарахаар байна. Энэ нь ойн ангийн дарга, мэргэжилтний албан тушаалын ангилал, зэрэглэлийг дараах хүснэгтээр тооцон үзвэл.

Хүснэгт 18. Ойн ангид шаардагдах зардал /ТЗ, төг/

Ажлын байр /ТЗ/	Цалин /төг/	Орон тоо	Нийт сард /төг/	Нийт жилд /төг/
-----------------	-------------	----------	-----------------	-----------------

1	Ойн ангийн дарга	2,171,947	46	99,909,562	1,198,914,744
2	Мэргэжилтэн	1,994,962	184	367,073,008	4,404,876,096
НДШ12.5%				45,884,126	700,473,855
Нийт цалингийн зардал				512,899,696	6,304,264,695

Ойн ангийн албан хаагчийг ТҮ-ээс ТЗ ангилалд шилжүүлснээр дарга, мэргэжилтэн тус бүр дээрх цалинг дунжаар авах тооцоо гарч байгаа нь төрийн албан хаагчийн эрх зүйн байдлыг дордуулахаар байна. Энэхүү тооцоонд докторын зэрэг болон хоол унааны мөнгө, улирал хагас бүтэн жилийн үр дүнгийн урамшууллыг тооцоогүй болно.

Хувилбар 2.

Ойн ангийн албан хаагчийн эрх зүйн байдлыг дээрдүүлэх хүрээнд ТҮМ ангиллын тусдаа Боловсролын салбарын ТҮМ ангилалтай адилтган тусдаа төрийн үйлчилгээний мэргэжлийн ангиллыг бий болгож тус ангиллын дагуу цалинжуулах боломжтой байна. Энэ ангиллаар цалинг тооцон үзвэл дараах хүснэгтэд дурдсан цалингийн зардал төрд гарахаар байна. Үүнд:

Хүснэгт 19. Боловсролын салбарын ТҮМ ангиллын зэрэглэлтэй адилтган тусдаа ангилал зэрэглэлээр тооцсон зардал./төг/

№	Албан тушаалын зэрэглэл	Үндсэн цалин /төг/	Алба хаасан нэмэгдэл /төг/	Сарын нийт цалин /төг/	Улирлын үр дүн орсон цалин /төг/	Жилийн нийт цалин хөлс /төг/	Нийт дүн /төг/
1	ТҮМ-7 / Боловсролын салбар/ /дарга 46/	2,339,000	233,900	3,157,650	4,327,150	42,569,800	1,958,210,800
2	ТҮМ-6 / Боловсролын салбар/ /мэргэжилтэн 184/	1,870,800	187,080	2,525,580	3,460,980	34,048,560	6,264,935,040
НДШ12.5 %							1,027,893,230
Нийт дүн							8,223,145,840

Хүснэгт 20. Албан хаасны болон ур чадварын нэмэгдлийн хувь хэмжээ /хувь/

№	Албан тушаалын зэрэглэл	Алба хаасан нэмэгдэл хувь	Ур чадвар /хувь/	Нийт хувь хэмжээ
---	-------------------------	---------------------------	------------------	------------------

ТҮМ-7 / Боловсролын салбар/ /дарга 46/	10%	25%	35%
ТҮМ-6 / Боловсролын салбар/ /мэргэжилтэн 184/	10%	25%	35%

Хувилбар 3.

Хүснэгт 21. Ойн ангийн дарга ТЗ-5, мэргэжилтнийг ТҮМ-6 ангилал зэрэглэлээр тооцсон цалингийн зардал /төг/

№	Албан тушаалын зэрэглэл	Үндсэн цалин /төг/	Алба хаасан нэмэгдэл /төг/	Сарын нийт цалин /төг/	Улирлын үр дүн орсон цалин /төг/	Жилийн нийт цалин хөлс /төг/	Нийт дүн /төг/
1	ТЗ-5 / Боловсролын салбар/ /дарга 46/	2,497,000	249,700	3,445,860	4,694,360	46,344,320	2,131,838,720
2	ТҮМ-6 / Боловсролын салбар/ /мэргэжилтэн 184/	1,870,800	187,080	2,525,580	3,460,980	34,048,560	6,264,935,040
НДШ12.5 %							1,049,596,720
Нийт дүн							9,446,370,480

Хүснэгт 22. Албан хаасны болон зэрэг дэв, ур чадварын нэмэгдлийн хувь хэмжээ

№	Албан тушаалын зэрэглэл	Алба хаасан нэмэгдэл /хувь/	Ур чадвар /хувь/	Нийт хувь хэмжээ /хувь/
1	ТЗ-5 / Боловсролын салбар/ /дарга 46/	10%	28%	38%
2	ТҮМ-6 / Боловсролын салбар/ /мэргэжилтэн 184/	10%	25%	35%

Нэгдүгээр хувилбарын дагуу тооцож үзэхэд хүний нөөц, материаллаг зардал 371,382,699 төгрөгийн зардал, харин хоёрдугаар хувилбарын дагуу тооцож үзэхэд хүний нөөцийн болон материаллаг зардалд 576,980,004 төгрөг ойролцоогоор тооцоологдов.

Хүснэгт 23. Хүний нөөцийн болон материаллаг зардал /төг/

Хувилбар

Хүний нөөц /төг/

1	Хувилбар 1 одоо авч байгаа цалин /ТҮ-9, ТҮ-8/	6,304,264,695
2	Хувилбар 2 /ТҮМ-7, ТҮМ-6/	8,223,145,840
3	Хувилбар 3 /ТЗ-5, ТҮМ-6/	9,446,370,480

Дээрх тооцооноос үзэхэд ойн ангийн албан хаагчдийн хувьд 2 хувилбараар албан тушаалын ангилал, зэрэглэлийг авч үзсэн бөгөөд одоо авч байгаа цалингаас тус өндөр байхаар тооцогдож байгаа бөгөөд энэ хэмжээгээр төсөвт цалингийн зардал үүсгэж байна. Тухайлбал, ойн ангийн даргыг ТЗ-5 буюу шатлалаар, ойн ангийн мэргэжилтэн, ойн инженер нарыг төрийн үйлчилгээний мэргэжлийн ангилал буюу ТҮМ-6 аар тооцон нийт ойн ангийн 230 албан хаагчийн тооцож үзэхэд жилдээ 9,446,370,400 /есөн тэрбум дөрвөн зуун дөчин зургаан сая гурван зуун далан мянга дөрвөн зуун ная/ төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр байна. Энэхүү хүний нөөцийн зардлын хамгийн өндөр тооцооллыг /хувилбар 3/ цаашид үндсэн тооцоонд авсан болно.

2.4.5. Тусгай зориулалтын ой

Мэдээллийн санд оруулах, тусгай зориулалтын ойд хэрэгжүүлэх менежментийн төлөвлөгөөг боловсруулж, ойн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаар батлуулна. Тусгай зориулалтын ойн мэдээллийг мэдээллийн санд оруулахад бүртгэх, тооллого хийх, менежментийн төлөвлөгөө боловсруулах зэрэг шинэ ангилал үүсч байх тул үүнтэй холбоотой зардлыг тооцоолох нь зүйтэй. Систем хөгжүүлэлтийн зардал 50,000,000 төгрөг болох боловч байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад ойн мэдээллийн санд шинэ мэдээллийг оруулах техникийн нөхцөлийг хангахтай холбоотойгоор зардал тооцогдсон бөгөөд тус зардлын хүрээнд шийдвэрлэх боломжтой байна. Тусгай зориулалтын ой нь бүртгэл, тооллого хийх, менежментийн төлөвлөгөөг боловсруулахад 3,1 хүний ажиллах хүч хэрэгтэй гэж тооцоолвол:

Хүснэгт 24. Тусгай зориулалтын ойтой холбоотой хүний нөөцийн зардал /төг/

Нэгж	Нэмэгдэж буй ачаалал /хүний тоо/	Нэг албан хаагчийн 1 жилийн цалингийн зардал /төг/	Хүний нөөцийн зардал /төг/
Тусгай зориулалтын ой	1	27,267,276	29,994,003

Нэг хүнд оногдох материаллаг зардлыг 5,395,434 гэж тооцвол 1 хүн цаг нь 5,934,977 төгрөг байна.

Хуулийн төсөлд тусгасан улсын ойн менежментийн төлөвлөгөөг боловсруулахдаа ойн тооллого, ой зохион байгуулалт, зайнаас тандан судалгаа, экологийн үнэлгээ, нийгэм, эдийн засгийн болон уур амьсгалын эрсдэлийн үнэлгээнд үндэслэнэ гэж зохицуулснаар уур амьсгалын эрсдэлийн үнэлгээ хийхэд зардал гарахаар хуульчлагджээ. Улсын ойн менежментийн төлөвлөгөө болон уур амьсгалын эрсдэлийн үнэлгээг хэн хийх эрх бүхий этгээд гэдэг нь тодорхойгүй байна. Үүнтэй холбоотойгоор хэнээр хийлгэхээ тодорхойлж зардлыг тодорхойлох шаардлагатай байна. Харин улсын менежментийн төлөвлөгөөг боловсруулах санал авах, батлуулахтай холбоотой чиг үүрэг нь байнга давтагдах шинжгүй тул байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын байгалийн нөөцийн газрын ойн асуудал хариуцсан албан хаагч чиг үүргийг хүрээнд хийх боломжтой байна.

Хуулийн 12 дугаар зүйлийн 12.5 -д зааснаар хушин ой, самрын нөөц ихтэй сум нь самрын менежментийн дэд төлөвлөгөө боловсруулж, батлууна гэж зааснаар самрын менежментийн дэд төлөвлөгөө ойролцоогоор мэргэжлийн хүнээр хийлгэхэд 15-25 сая төгрөг байна. Сум, орон нутаг ойн ангитай зөвшилцсөн бол үндсэн ажилчид өөрсдөө хийх тохиолдолд нэмэлтээр зардал гарахааргүй байна. Хушин ойн тархац Монгол улсад нийт судалгаагаар 7 аймагт үнэлэгдсэн байдаг тул нийт мэргэжлийн хүнээр хийлгүүлэх зардал 105,000,000 төгрөг байна.

Хуулийн төслийн 21 дүгээр зүйлийн 21.4 хэсэгт самар бэлтгэх, тээвэрлэх, хадгалах, худалдаалах үйл ажиллагааг гарал үүслийн бүртгэл, мөрдөн хянах тогтолцоонд хамруулна гэж зохицуулсан нь хаана зардал үүсэхийг тодорхой хуульчилж өгөөгүй байна. Уг гарал үүслийн бүртгэл, мөрдөн хянах тогтолцоонд хамруулах субьектийг тодорхойлж өгөх шаардлагатай. Утгаар нь авч үзвэл төрд зардал үүсэхээр байна.

Хүснэгт 25.Төрийн байгууллагад үүсэх нийт зардлын хэмжээ (жилд, төгрөг)

Үүрэг буюу ажил, үйлчилгээ	Зардлын төрөл	Зардлын хэмжээ нийт (1 жилд) /төг/	Хүний нөөцийн хэрэгцээ
Ойжуулалтын сан	Хүний нөөцийн зардал	517,630,230	5
	Материаллаг зардал	59,349,774	
Нүүрстөрөгчийн сан	Хүний нөөцийн зардал	517,630,230	
	Материаллаг зардал	59,349,774	
Ойн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад холбоотой нэгдсэн системийн бүртгэл, цахим хөгжүүлэлт, зөвшөөрлийн цахим мэдээллийн системийн хөгжүүлэлт, Тусгай зориулалтын ой	Хүний нөөцийн зардал	63,911,835	3.1
	Нэг удаагийн бусад зардал	250,000,000	
	Материаллаг зардал	16,725,845.4	
Ойн анги	Хүний нөөцийн зардал	1,590,917,176	-
	Материаллаг зардал	-	
НИЙТ ДҮН		3,075,514,864	8.1

2.5. Хувилбарыг нягталж, үр дүнг танилцуулах.

Хялбарчлах боломжийг шалгах үе шатанд өмнөх үе шатанд тодорхойлсон байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, ойн газар болон ойн ангийн чиг үүрэг нэг бүрийг хэрэгжүүлэхтэй холбоотой зардал, хүний нөөцийн ачааллыг бууруулах боломжийг тус бүрт нь нарийвчлан үнэлэв. Энэ хүрээнд тохиолдлын тоо, мэдээлэл хүргүүлэх давтамж, мэдээллийн агуулга, цахимжуулалтын боломж болон мэдээлэл хүлээн авагч байгууллагын зохион байгуулалтын оновчлол зэрэг үндсэн таван чиглэлээр дүгнэлт хийлээ. Үүнд:

2.5.1. Тохиолдлын тоог багасгах боломж байгаа эсэх;

Тохиолдлын тоо нь төрийн байгууллага тухайн чиг үүргийг жилд хэдэн удаа хэрэгжүүлэхийг илэрхийлдэг бөгөөд хүний нөөцийн ачаалал, нийт зардлыг тодорхойлох үндсэн үзүүлэлт юм. Судлагдсан чиг үүргүүдийн хувьд ойн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллага, ойн агентлаг болон ойн ангийн үйл ажиллагаа нь хуульд заасан тогтмол хяналт, шалгалт, тайлагнал, шийдвэр гаргалттай холбоотой тул бүрэн хэмжээгээр бууруулах боломж хязгаарлагдмал байна. Гэсэн хэдий ч зарим ижил төрлийн үйл ажиллагааг нэгтгэн зохион байгуулах, тухайлбал хяналт шалгалт болон тайлагналын мөчлөгийг багцлан улирал эсвэл хагас жилээр хэрэгжүүлэх, давхар хяналтын шинжтэй ажиллагааг нэг дор нэгтгэх, мөн зарим мэдээллийн боловсруулалтыг төвлөрүүлэн хийх замаар давтамжийг оновчлох боломж байна. Түүнчлэн 2 сангийн ажлын албан бүтцийг байгаль орчны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын санхүү, хөрөнгө оруулалтын газарт давхар гүйцэтгүүлэх боломжтой байна. Иймээс тохиолдлын тоог огцом бууруулах боломжгүй боловч үйл ажиллагааны давхардлыг арилгах, нэгтгэх замаар тодорхой хэмжээнд ачааллыг бууруулах боломжтой гэж дүгнэв.

2.5.2. Үйл ажиллагааны давтамжийг багасгах боломж байгаа эсэх;

Үйл ажиллагааны давтамж нь шийдвэр, дүгнэлт, тайлан, хяналтын мэдээллийг холбогдох байгууллага болон этгээдэд хүргэх давтамжийг илэрхийлдэг. Судалгааны үр дүнгээс харахад олон тохиолдолд ижил агуулгатай мэдээлэл өөр өөр цаг хугацаанд, тус тусдаа хүргэгдэж байгаа нь давхардал үүсгэж байна. Иймээс мэдээллийг нэгтгэн багц шийдвэрийн хэлбэрээр хүргэх, нэгтгэсэн байдлаар шийдвэрлэх, мөн цахим системээр дамжуулан олон этгээдэд нэгэн зэрэг хүргэх зохион байгуулалт нэвтрүүлэх боломжтой байна. Энэ өөрчлөлтийг хэрэгжүүлснээр мэдээлэл хүргэх давтамж буурч, улмаар бичиг хэргийн зардал, хүний нөөцийн ачаалал буурах эерэг нөлөө үзүүлэхээр байна.

III. ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ЗАРДЛЫН ТООЦОО

2.1 Хуулийн этгээдийн зардлыг тооцох

Байгууллагын бүтэц бүрэлдэхүүн, зардал, ажлын ачаалалд нөлөө үзүүлэх боломжтой зохицуулалтыг сонгож авахдаа дараах чиг үүргийг “одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа зохицуулалтыг зардлын тооцоонд оруулаагүй болно.

Нэгдүгээр үе шатны хүрээнд Ойн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл батлагдсанаар хуулийн этгээдэд ямар үүргийг шинээр бий болгож байгааг тодорхойлж уг үүргийг гүйцэтгэхэд шаардлагатай хугацаа, давтамж, тохиолдлын тоог тодорхойлсны үндсэн дээр зардлын тооцоог хийх юм. Энэ дагуу хуулийн шинэчилсэн найруулгын төслийг судлан үзэхэд хуулийн этгээдэд шууд зардлыг тусгаагүй үүрэг бий болгосон заалтууд байна.

Ойн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд ойгоос бэлтгэсэн мод, модон материалыг аймаг, сум, хот, суурины хооронд тээвэрлэх, худалдахдаа гарал үүслийн гэрчилгээтэй байх, уг гэрчилгээг цахимаар авах, өөрийн тарьж ургуулсан модыг ойгоор бүртгүүлэх хүсэлтээ ойн ангид цахимаар хүргүүлэхээр тус тус тусгасан байна.

“Төлбөрийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 2020 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн засгийн газрын 184 дугаар тогтоолд⁶ дурдсанаар мод тээврийн зай 50 км хүртэл дундаж дүн 45,200 төгрөг байна. Одоогийн хэрэгжиж буй Ойн тухай хуулиар уг гарал үүслийн гэрчилгээг цахимаар олгохоор зохицуулж байгаагүй ба практикт цахимаар гэрчилгээг аль хэдийн олгож эхлэсэн нь тус хуулийн шинэчилсэн найруулгаар Ойн тухай хуулийн гарал үүслийн гэрчилгээг олгох үйл ажиллагааны хэрэгжилтийг цахим засаглал руу шилжүүлэх болсон нь сайшаалтай байна. Гэрчилгээг цахимаар олговол цахим гэрчилгээний үнэ одоогийн үнээс бага зэрэг нэмэгдэх магадлалтай.

⁶ Монгол Улсын Засгийн газрын тогтоол, Дугаар 184, Төлбөрийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай, 2020.11.14, <https://legalinfo.mn/mn/detail?lawId=211377&showType=1> 2026.05.01,

Хуулийн төслийн 26 дугаар зүйлийн 26.2 -т зааснаар Мод боловсруулах үйлдвэрлэл эрхлэгч нь үйлдвэрлэлийн үйл явцад энэ хуулийн 53 дугаар зүйлд заасны дагуу баталгаажуулалт хийлгэж болно.”, 53 дугаар зүйлийн 53.5-д “Ойн тогтвортой менежментийн баталгаажуулалтыг сайн дурын үндсэн дээр гуравдагч этгээдээр хөндлөнгийн байдлаар үнэлүүлж баталгаажуулна.”, 53.6-д “Ойн тогтвортой менежментийн баталгаажуулалтыг Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн

тухай хуульд заасны дагуу итгэмжлэгдсэн, эсхүл бүртгүүлсэн баталгаажуулалтын байгууллага /цаашид "баталгаажуулалтын байгууллага" гэх/ гүйцэтгэнэ.” гэж тус тус тусгасан нь мөн бусад байдлаар үүрэгтэй гээд түүхий эдийн гарал үүслийг нотлох, технологийн алдагдал, хаягдлыг бууруулах, үлдэгдэл биомассыг биоэдийн засгийн эргэлтэд оруулах, үйлдвэрлэлийн үйл ажиллагааг цахим бүртгэл, тайлагналтай уялдуулах, хөдөлмөрийн аюулгүй байдал, байгаль орчны стандартыг мөрдөх зэргээр үүрэгжүүлж өгсөн байх тул хуулийн этгээдэд тодорхойгүй хэмжээнд зардал үүсэхээр байна.

Ойн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн дугаар зүйлийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь хэсэгт үйлдвэрлэлийн мод бэлтгэгч нь дараах шаардлагыг хангасан байна гээд тухайн ойн бүсийн ангилал, дэглэмд нийцсэн байх;ойн менежментийн төлөвлөгөөнд үндэслэсэн байх; дэвшилтэт, ногоон технологи ашигласан байх; нөөцийг хаягдалгүй үр ашигтай, тогтвортой ашиглах, хаягдлыг бууруулах, үлдэгдэл биомассыг био-эдийн засгийн эргэлтэд оруулах; ойн нөөцийн гарал үүсэл тодорхой байх, ул мөрийг мөшгөх тогтолцоог нэвтрүүлсэн байх; нөөцийн гарал үүсэл, бүтээгдэхүүний үйлдвэрлэл, экспортын тоо хэмжээг цахим системд бүртгэх, тайлагнах; үйлдвэрлэл, үйлчилгээ явуулах, нөхөн сэргээх, хамгаалах санхүүжилтийн эх үүсвэртэй байх; орон нутгийн иргэд, нөхөрлөл, уугуул иргэдийн эрх, ашиг сонирхлыг харгалзсан байх; холбогдох стандарт, техникийн зохицуулалтын шаардлагыг хангасан байх шаардлагуудыг тусгасан байна. Энэ заалтын хүрээнд иргэн, хуулийн этгээдэд бэлтгэж өгөхтэй холбоотой ойролцоогоор 15,000,000 - 20,000,000⁷ сая төгрөгийн зардал үүсэхээр байна.

Харин хуулийн төслийн 28 дугаар зүйлийн 28.8 дахь хэсэгт зааснаар гарал үүсэл, хэмжээ, бэлтгэл, тээвэрлэлт, худалдааны бүртгэлтэй байхад мөн иргэн, хуулийн этгээдэд 5,000,000- 8,000,000⁸ төгрөгийн зардал үүсэхээр байна.

Ой бүхий нутгийн иргэдэд шинэ хуулийн дагуу нэмэлт зардал тавигдахгүй бөгөөд харин ашиглалтын давуу эрх (46 дугаар зүйл) болон орлогын хуваарилалтын заалтаар эдийн засгийн ашиг нэмэгдэнэ.

Иймд, аргачлалд заасны дагуу цаашид зардал үүсгэх эсэхийг ойролцоогоор тооцоолоход Ойн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл нь хуулийн этгээдэд 24,000,000 төгрөгийн зардал үүсгэхээр байна.

Хүснэгт 25.Хуулийн этгээдийн гаргаж өгөх мэдээллийн холбогдох зохицуулалт

Хуулийн төслийн нэр	Хуулийн этгээдийн гүйцэтгэх чиг үүрэгтэй холбогдох зохицуулалт
Ойн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл	23.6.Иргэн, хуулийн этгээд мод бэлтгэх хүсэлтээ тухайн орон нутгийг хариуцсан ойн ангид цахим системээр дамжуулан гаргана. 23.8.Ойгоос бэлтгэсэн мод, модон материалыг аймаг, сум, хот, суурины хооронд тээвэрлэх, худалдахдаа цахим гарал үүслийн гэрчилгээтэй байна. Гэрчилгээг тухайн орон нутгийг хариуцсан ойн анги цахим системээр олгоно.

23.7.Хүсэлтийг энэ хуулийн 21.2-т заасан шаардлагыг хангасан хуулийн этгээдэд мод бэлтгэх цахим эрхийн бичгийг олгоно.

21. 2.Ойн эдийн засгийн үйлдвэрлэл, үйлчилгээ нь дараах нийтлэг шаардлагыг хангасан байна:

21.2.1.тухайн ойн бүсийн ангилал, дэглэмд нийцсэн байх;

21.2.2.ойн менежментийн төлөвлөгөөнд үндэслэсэн байх;

21.2.3.дэвшилтэт, ногоон технологи ашигласан байх;

21.2.4.нөөцийг хаягдалгүй үр ашигтай, тогтвортой ашиглах, хаягдлыг бууруулах, үлдэгдэл биомассыг био-эдийн засгийн эргэлтэд оруулах.

21.2.5.ойн нөөцийн гарал үүсэл тодорхой байх, ул мөрийг мөшгөх тогтолцоог нэвтрүүлсэн байх;

21.2.6.нөөцийн гарал үүсэл, бүтээгдэхүүний үйлдвэрлэл, экспортын тоо хэмжээг цахим системд бүртгэх, тайлагнах;

21.2.7.үйлдвэрлэл, үйлчилгээ явуулах, нөхөн сэргээх, хамгаалах санхүүжилтийн эх үүсвэртэй байх;

21.2.8.орон нутгийн иргэд, нөхөрлөл, уугуул иргэдийн эрх, ашиг сонирхлыг харгалзсан байх;

21.2.9.холбогдох стандарт, техникийн зохицуулалтын шаардлагыг хангах;

21.2.10.хуульд заасан бусад.

27. 1.Ойн дагалт баялгийг түүж бэлтгэх, боловсруулах үйл ажиллагаанд дараах шаардлага тавигдана:

27.1.1.нөөц, нөхөн сэргэлтийн чадавхад үндэслэсэн байх;

27.1.2.түүж бэлтгэх хэмжээ, квот, бүсчлэл, хугацааг мөрдөх.

45.1.5.Ойн дагалт баялгийг ашиглах, хамгаалах үйл ажиллагаа эрхлэхдээ биологич (ургамал судлаач), дагалт баялаг түүж бэлтгэх багтай байх.

46.4.Ойн нөөц ашигласны төлбөр, дагалт баялаг ашиглалтын төлбөр, нүүрстөрөгчийн орлого болон хуульд заасан бусад орлогын тодорхой хэсгийг ой хамгаалалт, нөхөн сэргээлт, ойн нөхөрлөлийн үйл ажиллагаанд зарцуулна.

IV. ИРГЭНД ҮҮСЭХ ЗАРДЛЫН ТООЦООЛОЛ

Аргачлалын 3.1 болон 3.2-т заасны дагуу дараах үе шатаар иргэний зардлыг тооцно. Үүнд:

- 1) Иргэний гүйцэтгэх үүргийг тогтоох;
- 2) Зардлыг тооцох;
- 3) Тоон үзүүлэлтийг тооцох; 4) Нийт зардлын дүнг тооцож гаргах; 5) Хялбарчлах боломжийг шалгах.
- 6) Мөнгөн зардлаас гадна зарцуулах хугацаа (ачаалал)-г тооцох.

Нэгдүгээр үе шатны хүрээнд Ойн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл батлагдсанаар иргэнд ямар үүргийг шинээр бий болгож байгааг тодорхойлсны үндсэн дээр зардлын тооцоог хийх юм. Энэ дагуу хуулийн шинэчилсэн найруулгын төслийг судлан үзэхэд иргэнд зардал үүсэхээр үүрэг бий болгосон заалтууд байна. Харин тус хуулийн төслийн 4 дүгээр зүйлийн 4.19-т

Ойн сангийн тодорхой хэсгийг ашиглагч, эзэмшигчийн үйл ажиллагааны улмаас иргэн, хуулийн этгээд, байгаль орчинд учирсан хохирлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу нөхөн төлүүлнэ гэж заасан нь иргэн, хуулийн этгээдэд үүсч болох тодорхойгүй зардал юм.

Ойн тухай хуулийн шинэчилсэн найруулгын 20 дугаар зүйлийн 20.2 дахь хэсэгт иргэн нь ойн баялгийг хууль бусаар ашигласан, гэмтээсэн, устгаж сүйтгэсэн зөрчлийн талаар тухайн шатны Засаг дарга, улсын байцаагч, байгаль хамгаалагчид нэн даруй мэдэгдэх; ойг хамгаалах үндэсний уламжлал, ёс заншлыг сахиж, хүүхэддээ экологийн хүмүүжил олгох; гал түймрийн улсын хяналтын дүрмийг чанд биелүүлж, түймрийн аюултай үед ил задгай гал түлэхгүй байх, асаасан шүдэнз, татсан тамхины гал, цог, нурмыг бүрэн унтрааж аюулгүй болгох; гэр, байшин, хураасан өвс, хашаа, саравчны эргэн тойронд хамгаалалтын зурвас татах болон түймэр унтраах байнгын багаж хэрэгсэлтэй байх; өрх бүр үнс, нурмыг тусгайлан бэлдсэн таглаа бүхий нүх, саванд хийж, түймэр алдахгүй байх нөхцөлийг хангах; ой, хээрийн түймрээс амь бие, эрүүл мэнд, эд хөрөнгөө хамгаалах, түймэр унтраах анхан шатны арга ажиллагааг эзэмшсэн байх, хүүхдээ түймрээс сэрэмжлүүлж сургах; тээврийн болон өөрөө явагч хэрэгслийг галын аюулгүйн төхөөрөмжөөр тоноглох, галын аюултай бодис, шатах, тослох материалыг хадгалах горимыг чанд мөрдөх; хуурай өвс, ургамлын хучаас, тариалангийн талбайн сүрэл, хог ургамал, өтөг бууцыг шагаахгүй байх; ой, хээрийн түймрийг унтраах ажиллагаанд иргэний журамт үүргийн дагуу оролцох, хувийн эзэмшлийн тээврийн хэрэгслээ ашиглуулах болон ой, хээрийн түймэр илрүүлсэн, түймрийн тухай мэдээ хүлээн авсан бол түүнийг унтраах арга хэмжээг шуурхай авч, холбогдох шатны Засаг дарга, бусад шаардлагатай байгууллагад яаралтай мэдээлэх зэрэг тооцох боломжгүй үүргийг тусгажээ.

Хуулийн төслийн 19 дүгээр зүйлийн 19.7 дахь хэсэгт “Энэ хуулийн 19.1.2-т заасны дагуу ойжуулалтын зориулалтаар эзэмшүүлэх газрыг олгох асуудлыг төсөл сонгон шалгаруулах замаар шийдвэрлэнэ.” 24 дүгээр зүйлийн 24.3 дахь хэсэгт сонгон шалгаруулалтад оролцогч нь дараах шалгуурыг хангаж байна гээд техникийн болон мэргэжлийн чадавх, байгаль орчны менежментийн туршлага, санхүүгийн чадавх, нөхөн сэргээлтийн баталгаа, орон нутгийн оролцоо, ашиг хүртээмжийн санал, мэдээллийн ил тод байдал, тайлагналын чадавх зэрэг сонгон шалгаруулалтад оролцоход иргэнд 20,000,000 - 25,000,000 төгрөгийн зардал үүсэхээр байна.

V. ДҮГНЭЛТ

Монгол орны ойн нөөц нийт нутаг дэвсгэрийн 8.1 орчим хувийг (11.2 сая га гаруй) эзэлж буй боловч сүүлийн хэдэн арван жилийн турш хүний үйл ажиллагаа, цаг агаарын эрс өөрчлөлт, ой, хээрийн түймрийн улмаас ойн нөөц мэдэгдэхүйц буурсаар байна. 1990 оноос хойш нийт ойн талбайн 600,000 гаруй га устаж, ойн доройтлын хэмжээ жилдээ 30,000-40,000 га-д хүрч байгаа нь хяналт бүхий, нэгдсэн хууль эрх зүйн зохицуулалт шаардаж байна.

2012 онд батлагдсан Ойн тухай хууль нь орчин үеийн ойн менежментийн болон нийгэм, эдийн засгийн хэрэгцээнд нийцэхгүй болсон тул “Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”, “Алсын Харааны 2050”, “Монгол Улсын хууль тогтоомжийг 2028 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл” баримт бичигт нийцсэн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах шаардлага үүссэн байна.

Ойн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд дараах агуулга бүхий зүйл, хэсэг, заалтыг тусгасан байна. Үүнд:

- Ойн сан ангилал / Ойн сан, ойн сангийн газар, түүний ангилал, Хамгаалалтын бүсийн ой, Ашиглалтын бүсийн ой, Тусгай зориулалтын ой, Ойн сангийн газрын ашиглалтын нийтлэг шаардлага/
- Ойн менежмент / Улсын ойн менежментийн төлөвлөгөө, Аймаг, нийслэл, сумын ойн менежмент, Эзэмшлийн ойн менежмент, Ойн төр- хувийн хэвшлийн түншлэл, гэрээт менежмент, Ойн тооллого, ой зохион байгуулалт, нөөцийн үнэлгээ, Ойн мэдээллийн нэгдсэн систем/
- Ойн эдийн засаг / Ойн эдийн засгийн үйл ажиллагаа, Ойн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, Мод боловсруулах үйлдвэрлэл, Ойн дагалт баялгийн эдийн засаг, самрын менежмент, Ойн нүүрстөрөгчийн зах зээл, Био-эдийн засаг,
- Ойн ашиглалт /Ой ашиглах эрх, Мод бэлтгэл, Түлээний мод, Үйлдвэрлэлийн мод, Ойн дагалт баялаг ашиглалт, Ойн түншлэл, гэрээт менежментийн шалгаруулалт/
- Ойн нөхөн сэргээлт /Ойжуулалт, Нөхөн сэргээлт, Агро- Ойн аж ахуй, Хушин ойн хамгаалалт/
- Орон нутгийн оролцоо /Ойн нөхөрлөл, Ой бүхий нутгийн иргэдийн эрх, Орон нутгийн давуу эрх/
- Төрийн байгууллагын бүрэн эрх / Улсын Их Хурлын бүрэн эрх, Засгийн газрын бүрэн эрх, Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх, Ойн агентлагийн бүрэн эрх /
- Орон нутаг ба гүйцэтгэх тогтолцоо /Аймгийн Засаг даргын бүрэн эрх, үүрэг, Сумын Засаг даргын бүрэн эрх, Ойн анги, Сум дундын ойн анги, Ойн мэргэжлийн байгууллага, түүний үйл ажиллагаа, Салбар дундын уялдаа хамтын ажиллагаа, Ойн салбарын хяналт, ил тод байдал, цахим тогтолцоо/
- Цахимжилт /Ойн үйл ажиллагааны цахимжилт, Авилгаас урьдчилан сэргийлэх, ил тод байдлын тогтолцоо/
- Санхүүжилт, сан, хөрөнгө оруулалт /Ойжуулалтын сан, Нүүрстөрөгчийн сан, Ойжуулалтын сангийн эх үүсвэр, Ойн хөрөнгө оруулалт, хувийн хэвшлийн оролцоо, Иргэд, ойн нөхөрлөл, оролцоо, ашиг хүртэх/
- Хариуцлага / Хууль зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлага, Байгаль орчинд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх, Эрхийг түдгэлзүүлэх, цуцах, Хууль хүчин төгөлдөр болох/.

Тухайн хуулийн төслийн хүрээнд төрийн байгууллага, иргэд, хуулийн этгээдэд илүү үүрэг болгосон зохицуулалтууд нэмэгдсэн ба нөхөн төлбөр, нөхөн сэргээлт, хохирлыг барагдуулах зэрэг тодорхойгүй зардал нэмэгдсэн байна.

5.1.Төрд:

- тусгай зориулалтын ойн ангилал, түүний дэглэм, зохион байгуулалт,
- улсын менежментийн төлөвлөгөө, түүнийг боловсруулах, батлуулах, хэрэгжүүлэх, хяналт тавих, тайлагнах,
- ойн мэдээллийн сан, түүнийг бүрдүүлэгч хэсэг, зохион байгуулалт, цахим зөвшөөрөл олголт, санхүүжилт,
- ойжуулалтын болон нүүрстөрөгчийн сангийн удирдлага зохион байгуулалт, хяналт, тайлагналт гэх мэт.

Дээрх төрд зардал үүсгэх чиг үүрэг нь:

- байгаль орчны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага,
- ойн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага,
- ойн анги зэрэгт хүний нөөцийн болон материаллаг, нэг удаагийн шинжтэй зардал үүсэхээр байна.

5.1.1.байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад үүсэх зардал.

Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад ойжуулалтын сан болон нүүрстөрөгчийн сан ажлын албатай байх эсэх нь хуулийн төсөлд тодорхойгүй байх бөгөөд чиг үүргийг харгалзан тухай сангийн ажлын албаны чиг үүргийг хэрэгжүүлэхэд дунджаар стандарт нөхцөлөөр тус бүр 5 хүний бүрэлдэхүүнтэй байх бөгөөд хүний нөөц болон материаллаг зардалд 1,153,960,008 төгрөгийн зардал, 118,699,548 төгрөгийг түрээсийн байрны зардалд тус тус зарцуулахаар байгаа нь төсөвт ихээхэн хэмжээний нөлөөлөл үүсгэхээр байна.

Иймд дээрх 2 сангийн ажлын албыг **нэгдүгээрт** нийлүүлж, 5 хүний орон тоотойгоор тусдаа байгуулахад 576,980,004 төгрөгийг цалингийн зардал жилд зарцуулах, эсхүл **хоёрдугаарт** 5 хүний чиг үүргийг Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газарт чиг үүргийг хавсран гүйцэтгүүлэх хэлбэрээр хариуцуулах боломжтой бөгөөд хүний нөөцийн цалингийн зардлыг 50 хувиар багасахаар байна.

Мөн нүүрстөрөгчийн санг хуулийн төсөлд байгуулж болохоор заасан бөгөөд тус санг үе шаттайгаар байгуулж улсын төсөвд бага хэмжээний ачаалал үүсгэх боломжтой.

Монгол Улсын Засгийн газраас 2018 онд Засгийн газрын тусгай сангийн үйл ажиллагаанд хяналт, шалгалтыг хийсэн бөгөөд цаашид шинээр сан нэмэхгүй байхаар шийдвэрлэсэн байдаг нь дээрх 2 сан байгуулагдахад эрсдэлтэй байгааг анхаарах нь зүйтэй байна.

5.1.2.Ойн газар үүсэх зардал.

Ойн газарт ойн тусгай зориулалтын ойн ангиллыг нэмсэн, түүний дэглэмийн зохицуулалт, мэдээллийн сангийн мэдээллийг өргөжүүлэхээр тусгасан, зөвшөөрлийг цахимаар олгох болсонтой холбоотойгоор программ шинэчлэл, хөгжүүлэлтийн ажлыг гүйцэтгэхтэй холбоотой нэг удаагийн болон урсгал, хүний нөөцийн зардал үүсэхээр байгаа бөгөөд нэг удаагийн зардалд 250 000 000 төгрөг/программ шинэчлэлийн зардал буюу хатуу болон зөөлөн дэд бүтэц/ зарцуулах, 4.1 хүний цалингийн зардал нийт 587,550,809 төгрөгийн зардал гарахаар тооцогдсон болно.

Дээрх 4.1 хүний цалингийн болон материаллаг зардлыг Ойн газрын холбогдох албан хаагчийн чиг үүргийн хүрээнд хавсран гүйцэтгэж, зардлыг хэмнэж болохоор байх боловч нэг удаагийн программ хөгжүүлэлтийн зардал нь зайлшгүй байна. Харин энэхүү нэг удаагийн программ хөгжүүлэлтийн зардлыг олон улсын төсөл хөтөлбөрийн хүрээнд шийдвэрлэх боломжтой гэж үзэж байна.

5.1.3.Ойн ангид үүсэх хүний нөөцийн цалингийн зардалд

Ойн ангийн албан хаагчийн эрх зүйн байдлыг дээрдүүлэх хүрээнд хуулийн төсөл, төслийн үзэл баримтлалд тусгасан төрийн албан хаагчийн ангилал, зэрэглэлийг өөрчлөх байдлаар хүний нөөцийн буюу цалингийн зардлыг 2 хувилбараар нэмэгдүүлж тооцсон болно.

Тухайлбал, 1 дүгээр хувилбарын хувьд төрийн үйлчилгээний мэргэжлийн тусгайлсан ангилал, шатлалыг бий болгох байдлаар /ойн дарга ТҮМ-7, мэргэжилтэн ТҮМ-6/ цалинг нэмэгдүүлсэн бөгөөд энэ жилд 8,223,145,840 /230 албан хаагч/ төгрөг болохоор байна. Энэ нь одоогийн нийт 46 ойн ангийн 230 албан хаагчид жилд зарцуулж байгаа зардлаас дунджаар 1.9 тэрбум төгрөгөөр илүү байна. Харин хоёрдугаар хувилбар буюу ойн ангийн дарга ТЗ-5, мэргэжилтэн ТҮМ-6 ангилал, шатлалд шилжүүлэн тооцоход жилд нийт 9,446,370,480 төгрөг буюу одоо ойн ангийн цалинд жилд зарцуулж байгаа зардал /7,855,453,301 төгрөг/-аас 1,5 тэрбум төгрөгөөр илүү нэмэлт зардал улсын төсвөөс цалингийн зардалд жилд зарцуулахаар байна.

Хүснэгт 27. Ойн ангийн албан хаагчийн шатлал, зэрэглэлийг өөрчлөн тооцсноос улсын төсөвт шинээр үүсэх зардлын зөрүү

	Хувилбар	Хүний нөөц /төг/	Зөрүү жилд/төг/
1	Одоо авч байгаа цалин /ТҮ-9, ТҮ-8/	7,855,453,301	-
2	Хувилбар 1 /ТҮМ-7, ТҮМ-6/	8,223,145,840	367,692,539
3	Хувилбар 2 /ТЗ-5, ТҮМ-6/	9,446,370,480	1,590,917,176

Төрийн байгууллагад үүсэх голлох зардал нь Ойн мэдээллийн нэгдсэн системийн бүртгэл, цахимжуулалт, тусгай зориулалтын ой, сан, ойн ангийн хүний нөөцтэй холбоотой цалингийн зардал болж байгаа бөгөөд үүнийг үе шаттайгаар шийдвэрлэх, олон улсын төсөл хөтөлбөрөөр хэрэгжүүлэхэд төсөвт жилд үзүүлэх нөлөөлөл нь багасах боломжтой.

Иймд төрөөс нийт 3,791,381,289 төгрөгийг зардал гарахаар тооцоологдлоо.

Хүснэгт 28. Төрөөс гарах нийт зардал /төг/

Үүрэг буюу ажил, үйлчилгээ	Зардлын төрөл	Зардлын хэмжээ нийт (1 жилд) /төг/	Хүний нөөцийн хэрэгцээ	Төрд үүсгэх зардлыг бууруулах хувилбар
Ойжуулалтын сан	Хүний нөөцийн зардал	517,630,230	5	235,286,468 /хүний нөөцийн зардал/
	Материаллаг зардал	59,349,774		
Нүүрстөрөгчийн сан	Хүний нөөцийн зардал	517,630,230		26,977,170 /материаллаг зардал/
	Материаллаг зардал	59,349,774		
Ойн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад холбоотой нэгдсэн системийн бүртгэл, цахим хөгжүүлэлт, зөвшөөрлийн цахим мэдээллийн системийн хөгжүүлэлт, тусгай зориулалтын ой ангилал.	Хүний нөөцийн зардал	63,911,835	3.1	63,911,835
	Нэг удаагийн бусад зардал	250,000,000		250,000,000
	Материаллаг зардал	16,725,845.4		16,725,845.4
Ойн анги	Хүний нөөцийн зардал	1,590,917,176	-	1,590,917,176

	Материаллаг зардал	-		-
НИЙТ ДҮН		3,075,514,864	8.1	2,183,818,494

5.2.1.Иргэн, хуулийн этгээдэд үүсэх зардалд.

Хуулийн этгээдэд 40,000,000 төгрөг, иргэнд 24,000,000 төгрөгийг стандарт зардал гарахаар урьдчилсан байдлаар тооцоологдож байгаа бөгөөд энэхүү зардлыг төрийн байгууллагын чиг үүргийн хүрээнд холбогдох албан тушаалтанд хавсран гүйцэтгүүлэх байдлаар чиг үүргийг хуваарилан 25 орчим хувийг хэмнэх боломжтой бөгөөд үе шаттайгаар зардлыг шийдвэрлэх нь төсөвт үүсэх ачааллыг буруулах боломжтой гэж үзэж байна.

Мөн хуулийн төсөлд иргэн, хуулийн этгээдэд тооцоолох боломжгүй, хууль зүйн үр дагавар үүсгэхгүй зохицуулалт ихээхэн орсон байгааг анхаарч сайжруулалт хийх нь зүйтэй байна.

АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ

Хууль тогтоомж, бодлогын баримт бичиг

1. Монгол Улсын Үндсэн хууль, 1992 он;
2. Агентлагийн тухай хууль, 2004 он;
3. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль, 2012 он;
4. Байгаль орчныг хамгаалах тухай хууль, 1995 он;
5. Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хууль, 2020 он;
6. Монгол Улсын Засгийн газрын тухай хууль, 1993 он;
7. Ойн тухай хууль, 2012 он;
8. Хууль тогтоомжийн тухай хууль, 2015 он;
9. Монгол Улсын Их Хурлын Тогтоол, Дугаар 52, “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогыг батлах тухай, 2020 он;
10. Монгол Улсын Их Хурлын Тогтоол, Дугаар 488 “Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалыг батлах тухай”, 2010 он;
11. Монгол Улсын Их Хурлын Тогтоол, Дугаар 21, “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай”, 2024 он;
12. Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг, Дугаар 350, "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай, 2021 он;
13. Монгол Улсын Засгийн Газрын Тогтоол, Дугаар 59, Аргачлал батлах тухай
14. Монгол Улсын Их Хурлын Тогтоол, Дугаар 106, “Шинэ сэргэлтийн бодлого батлах тухай”, 2021 он;
15. Монгол Улсын Засгийн Газрын Тогтоолын хавсралт, Тэрбум мод үндэсний хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээ;
16. Монгол Улсын Засгийн Газрын Тогтоол, Монгол Улсын хууль тогтоомжийг 2028 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл;

Ном, сурах бичиг, судалгаа

1. Хууль зүй, дотоод хэргийн яам, Германы Олон Улсын Хамтын Ажиллагааны Нийгэмлэг (GIZ)ийн “Эдийн засгийн тогтвортой хөгжлийн эрх зүйн орчинг баталгаажуулах төсөл”, Хууль тогтоомжийн тухай хууль, аргачлал, /Гарын авлага/, 2016 он;
2. Азийн хөгжлийн банк, ТТ-9899, Ойн салбарын хөгжлийн хөтөлбөр, Боть 2:Салбарын шинэчлэлийн стратеги, үйл ажиллагааны төлөвлөгөө, төгсгөлийн тайлан, 2023 он;
3. ТА-9899 МОН: Ойн салбарын хөгжлийн хөтөлбөр (сум дундын) ойн ангийн үнэлгээ Тайлангийн төсөл, 2023 он;
4. ТТ-9899 МОН: Ойн салбарын хөгжлийн хөтөлбөр тэрбум мод хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд Ойн нөхөрлөлүүдийн үйл ажиллагааг бэхжүүлэх заавар, 2023 он;
5. ТА-9899: Ойн салбарын хөгжлийн хөтөлбөр зах зээл ба өртгийн сүлжээний шинжилгээ, 2023 он;
6. ТА-9899 МОН: Ойн Салбарын Хөгжлийн Хөтөлбөр: 2-р боть: Салбарын шинэчлэлийн стратеги, Үйл ажиллагааны төлөвлөгөө Хавсралт А3: Ойн тогтвортой менежментийг хэрэгжүүлэх замын зураг, 2023 он;
7. ТА-9899 МОН: Ойн салбарын хөгжлийн хөтөлбөр /Ойн нөхөрлөлүүдэд хийсэн үнэлгээ/, 2023 он;
8. ҮСХ, Байгаль орчин-эдийн засгийн данс: Ойн нөөцийн данс-2023, 2024 он;
9. БОАЖЯ, Ойн судалгаа хөгжлийн төв, Монгол Улсын ойн сан /албан хэрэгцээнд/, 2020 он;
10. Б.Удвал, Хушны самрыг зүй зохистой түүж бэлтгэх, ашиглах гарын авлага, 2020 он;

Бусад

1. Монгол Улсын Ерөнхий сайдын 2023 оны 191 дүгээр захирамжаар байгуулагдсан ажлын хэсгийн ахлагч, Хууль зүй, дотоод хэргийн сайд Б.Энхбаярын баталсан “Захиргааны хэм хэмжээний актыг цэгцлэн хуулийн төсөл боловсруулах ажлын удирдамж”
2. МХЕГ, Ойн тухай хуулийн зөрчил, анхаарах асуудал сэдэвт танилцуулга, 2022 он;
3. Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Байгаль орчны төлөв байдлын тайлан (2019-2020 он), 2021 он;
4. Байгаль орчин, аялал жуулчлалын яам ойн судалгаа, хөгжлийн төв,” Монгол Улсын ойн сан”, 2019 он.

Гадаад хэл дээрх эх сурвалж

1. The forest code of the russian federation no. 200-fz of december 4, 2006, adopted by the state дума on november 8, 2006, endorsed by the federation council on november 24, 2006, https://www.wto.org/english/thewto_e/acc_e/rus_e/wtaccrus58_leg_255.pdf
2. The code of the republic of kazakhstan forest code of the republic of kazakhstan (as of july 8, 2003, no.477-ii), <https://faolex.fao.org/docs/pdf/kaz41426e.pdf>
3. Federal forest act of 2 may 1975 (federal law gazette i p. 1037), last amended by article 112 of the act of 10 august 2021 (federal law gazette i p. 3436), <https://www.gesetze-iminternet.de/bwaldg/bjnr010370975.html>

Цахим эх сурвалж

1. Байгаль орчныг хамгаалах арга хэмжээний төсөв, зардлын мэдээллийн сан, <https://finance.eic.mn/implement?y=2024&a>
2. ЕХ-ны 2030 оны Ойн Стратеги, https://environment.ec.europa.eu/strategy/foreststrategy_en
3. Монгол Улсын Их Хурлын 2024 оны 13 дугаар тогтоолын хавсралт, Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвч, <https://legalinfo.mn/mn/detail?lawId=17141010887611&showType=1>
4. Статистикийн мэдээллийн нэгдсэн - www.1212.mn
5. Судалгааны хүрээлэнгийн цахим хуудас: jtrii.mn